

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-14
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	15-56
<hr/>	
1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	16-25
2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	25-32
3.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	32
4.Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл	32-37 54
5.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл	37-54
6.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	55
7.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	55-56

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 26-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Эрдэнэболд;  
Чөлөөтэй: О.Алтангэрэл, Х.Баттулга, Э.Батшугар, Д.Батлут,  
Б.Дэлгэрсайхан, Б.Тулга, Х.Тэмүүжин;  
Тасалсан: Ж.Баярмаа.

**Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Очирбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын ахлах референт Д.Балжинням, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Т.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд /цашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн “цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл” гэсэн нэр томъёог хуулийн төслийн тохиолдол бүрд “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл” гэсэн нэр томъёог хуулийн төслийн тохиолдол бүрд “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“11<sup>1</sup> дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээний хяналт, зохицуулалт**

11<sup>1</sup>.1.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч

хуулийн этгээд нь аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.

11<sup>1</sup>.2.Энэ хуулийн 11<sup>1</sup>.1-д заасан гэрээнд нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой төлбөр, хураамж, зорчих бүсчлэл, зогсоолын талбайн байршил зэрэг талуудын эрх, үүргийн харилцааг зохицуулсан байна.

11<sup>1</sup>.3.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 11<sup>1</sup>.1-д заасан гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга нь үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсхүл гэрээг цуцлах арга хэмжээг авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

**“12<sup>1</sup> дүгээр зүйл.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг**

12<sup>1</sup>.1.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн энэ хуульд тусгайлан зааснаас бусад эрх, үүргийг Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох хуульд заасан журмын дагуу зохицуулна.

12<sup>1</sup>.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 буюу түүнээс дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцох эрхтэй.

12<sup>1</sup>.3.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн жолооч нь энэ хуулийн 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

12<sup>1</sup>.4.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup>.1-д заасан журмын дагуу бүртгүүлэх үүрэгтэй.

12<sup>1</sup>.5.Эцэг, эх, асран хамгаалагч нь 18 нас хүрээгүй хүүхдийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.2.2 дахь заалтын “цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг улсын бүртгэлд” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг” гэж өөрчилж, 13<sup>1</sup>.2.10, 13<sup>1</sup>.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13<sup>1</sup>.2.10.18 нас хүрээгүй хүүхэд болон энэ хуулийн 12<sup>1</sup>.3-т заасан сургалтад хамрагдаж, бүртгүүлээгүй хүнийг нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах;

13<sup>1</sup>.2.11.нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг болон 13<sup>1</sup>.2.3, 13<sup>1</sup>.2.4, 13<sup>1</sup>.2.5, 13<sup>1</sup>.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

3.1.13.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг нийтэд төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг;

3.1.14.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр хэрэглэгчид төлбөртэйгээр, тодорхой хугацаагаар ашиглуулах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн этгээдийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.*

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “мопедоос” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээс” гэж, 3.1.11 дэх заалтын “мопед” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.*

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.*

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 12<sup>1</sup>.4 дэх хэсэг болон 3 дахь заалтын 13<sup>1</sup>.2.11 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.*

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.*

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “58, 59, 60, 61, 62, 63, 64” гэснийг “59, 60, 61” гэж өөрчилж, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59 дэх хэсэг болгох:

“59.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 62 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“62.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 63.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.4.арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4, 63.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.*

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлүүдийг хэлэлцэж дуусав.*

*Төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, П.Сайнзориг нарын тавьсан асуултад итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** 1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.” гэж заасны “... 4 жил ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчөөр ... зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав./12:54/

*Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал 12 цаг 54 минутаас хуралдааныг даргалав.*

***Дөрөв.Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд, С.Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцэгээ, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга С.Ганзориг, Орон нутаг хариуцсан Тасгийн дарга Д.Ёндонжамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг сонсов.

**Х.Баасанжаргал:** Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Хүний эрхийн дэд хорооноос гаргасан саналыг Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгаж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 9  
Бүгд: 19  
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд, С.Дондов, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцэгээ, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга С.Ганзориг, Орон нутаг хариуцсан Тасгийн дарга Д.Ёндонжамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Цэнгүүн, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн Б.Энхболд, Г.Нарантуяа, Ж.Хунан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Х.Баасанжаргал:** “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг нарыг дэмжсэнээр тооцож, 63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 14 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Х.Баасанжаргал:** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 12

Бүгд: 19

36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Х.Баасанжаргал:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Х.Баасанжаргал:** “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явууля.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 28 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 67.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 10 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 12 цаг 00 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн.7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Дашдондогийн Ганбат, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтүяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн гэсэн 57.1 хувийн ирцтэйгээр хуралдааны ирцийн шаардлага хангагдсан байна.

Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг нарын 9 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

2.Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/.

4.Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгаалалын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл.

5.Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл.

6.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

7.Байнгын хорооны тогтоолын төсөл. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай. Ийм 7 асуудал байна.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

***Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг***

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Уянгахишиг гишүүний микрофоныг өгье өө.

**Г.Уянгахишиг:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд дийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар миний бие Уянгахишиг, гишүүдээр О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд нар ажиллаж байна. Түүнчлэн 2025 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүнийг Хэрэг эрхлэх газар болон Хууль зүй, дотоод хэргийн яам. Зам, тээврийн яам, Улсын Ерөнхий прокурорын газар, НЗДТГ, НИТХ, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба болон холбогдох хувийн хэвшлийн төлөөлийг оролцуулан баталсан болно. Энэ хугацаанд ажлын хэсэг тухай хуулийн тухай хуулийн төсөл болон хамт хурал хуралдаанд хуралдаанд ажлын

хэсэг 4 удаа ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн 6 удаа хуралдсан бөгөөд хуулийн төслийн талаар 12, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар 5 саналыг боловсруулан та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт, хуулийн төсөл дэх цахилгаан скүүтр, цахилгаан дугуй, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгслийг хууль тогтоомж, гэрээ конвенцод нийцүүлэх хүрээнд мопед түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл гэж нэр, томьёо, агуулгыг илүү тодорхой болгохоор, 2 дугаарт, нийтийн хэрэгцээний цахилгаан, дугуй, цахилгаан скүүтерийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж болохоор заасан. Нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, цахилгаан, скүүтерийн үйлчилгээний хяналт зохицуулалт гэсэн 11 штрих 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулж, нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь аймаг, НЗД-тай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх гэрээний нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй бол үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсвэл гэрээг цуцлах арга хэмжээг авахаар өөрчилж үүнтэй нийцүүлэн хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаахаар.

3.Мопед түүний төрөлд хамаарах скутер тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 нас хүрсэн хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохоор,

4.Мопед тэгээд түүний төрөлд хамаарах скүүтер тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журмын дагуу бүртгүүлдэг байхаар.

5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг ердийн журмаар дагаж мөрдөхөөр.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх зэрэг бөгөөд сана талуудыг томьёолон та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг боловсруулж тогтоолоор хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомж Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм, мопед, түүний төрөлд хамаарах скутер болон тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож холбогдох журмыг шинэчлэн батлах.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг хэрэглээний соёлыг төлөвшүүлэх, сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Уянгахишиг гишүүнд баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн нэрс УЕП-ын туслах прокурор Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын ахлах референт Д.Балжинням, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг ЗЦГ-ын Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газрын чиглэлийн ахлах зохицуулагч цагдаагийн дэд хурандаа Б.Наранцогт, ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Т.Эрхэмбаатар, ЗЦГ-ын Зам тээврийн хяналт төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн ахлах зохицуулагч цагдаагийн ахмад Д.Тэмүүжин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энд ирж ажиллаж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлнэ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Байнгын хороод урьдчилж бичгээр ирүүлсэн санал байхгүй байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн 8 саналаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

**Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх  
зарчмын зөрүүтэй саналын томъёолол**

1.Төслийн “цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл” гэсэн нэр томъёог хуулийн төслийн тохиолдол бүрд “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Одонтуяа гишүүн горимын санал гаргачих.

**С.Одонтуяа:** Энэ дарсан чинь миний кноп ажилласангүй. Тэгэхээр би дэмжсэн юм уг нь. Энэ саналыг хүчингүй болгож өгнө үү? Дахин санал хураалт явуулж өгнө үү.

**Д.Цогтбаатар:** Саяын саналыг Одонтуяа гишүүн санал дарсан боловч машин ажиллаагүй байна. Тэгэхээр саяын горимын саналыг санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61.3 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн тэгэхээр саналын томьёоллыг би уншиж танилцуулсан байгаа. Түрүүн уншиж танилцуулснаар саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалттай холбогдуулан Ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томьёолол

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“11<sup>1</sup> дүгээр зүйл.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээний хяналт, зохицуулалт**

11<sup>1</sup>.1.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ.

11<sup>1</sup>.2.Энэ хуулийн 11<sup>1</sup>.1-д заасан гэрээнд нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой төлбөр, хураамж, зорчих бүсчлэл, зогсоолын талбайн байршил зэрэг талуудын эрх үүргийн харилцааг зохицуулсан байна.

11<sup>1</sup>.3.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 11<sup>1</sup>.1-д заасан гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга нь үйл ажиллагааг нь түр хязгаарлах, эсхүл гэрээг цуцлах арга хэмжээг авна.” Гэсний дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

**“12<sup>1</sup> дүгээр зүйл.Мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг**

12<sup>1</sup>.1.Мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогчийн энэ хуульд тусгайлан зааснаас бусад эрх, үүргийг Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох хуульд заасан журмын дагуу зохицуулна.

12<sup>1</sup>.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 буюу түүнээс дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцох эрхтэй.

12<sup>1</sup>.3.Мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн жолооч нь энэ хуулийн 14.2-т заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

12<sup>1</sup>.4.Мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup>.1-д заасан журмын дагуу бүртгүүлэх үүрэгтэй.

12<sup>1</sup>.5.Эцэг, эх, асран хамгаалагч нь 18 нас хүрээгүй хүүхдийг мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналын томъёолол.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.1.2 дахь заалтыг хасах.

Аан энийг дахиад уншчихъя. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.1.2 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналын томъёолол.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.2.2 дахь заалтын “цахилгаан дугуй, цахилгаан сүүтерийг улсын бүртгэлд” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах сүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн

хэрэгслийг” гэж өөрчилж, 13<sup>1</sup>.2.10, 13<sup>1</sup>.2.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13<sup>1</sup>.2.10.18 нас хүрээгүй хүүхэд болон энэ хуулийн 12<sup>1</sup>.3-т заасан сургалтад хамрагдаж, бүртгүүлээгүй хүнийг нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах.

13<sup>1</sup>.2.11.нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдах.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13<sup>1</sup> дүгээр зүйлийн 13<sup>1</sup>.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг болон 13<sup>1</sup>.2.3, 13<sup>1</sup>.2.4, 13<sup>1</sup>.2.5, 13<sup>1</sup>.2.6 дахь заалтыг тус тус хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

3.1.13.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ” гэж өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг нийтэд төлбөртэйгээр ашиглуулах үйл ажиллагааг;

3.1.14.“Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч” гэж

өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр хэрэглэгчид төлбөртэйгээр, тодорхой хугацаагаар ашиглуулах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн этгээдийг.” гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.1 хувиар дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байвал нэрсээ өгье. Алга байна.

Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Байнгын хороонд урьдчилж бичгээр ирүүлсэн санал байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналаар санал хураалт явуулъя.

**9.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**“2 дугаар зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “мопедоос” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслээс” гэж, 3.1.11 дэх заалтын “мопед” гэснийг “мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж өөрчилсүгэй.” гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя санал гаргасан ажлын хэсэг санал хураана.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Өө алга байна.

Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр Байнгын хороонд урьдчилж бичгээр ирүүлсэн санал байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн 1 саналаар санал хураалт явуулъя.

**10.Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томьёолол.** Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэр өгнө үү. Алга байна.

Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр Байнгын хороонд урьдчилж бичгээр ирүүлсэн санал байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналаар санал хураалт явуулъя.

11.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 12<sup>1</sup>.4 дэх хэсэг болон 3 дахь заалтын 13<sup>1</sup>.2.11 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

12.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгье. Алга байна Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Байнгын хороонд

урьдчилж бичгээр ирүүлсэн санал байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн 4 саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “58, 59, 60, 61, 62, 63, 64” гэснийг “59, 60, 61” гэж өөрчилж, 58 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59 дэх хэсэг болгох:

“59.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томъёолол.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 62 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“62.Мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон арван найман нас хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураая.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томъёолол томъёолол.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 63.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“63.4.арван найман нас хүрээгүй хүүхэд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-т заасан сургалтад хамрагдаагүй хүнийг мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 59,60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4, 63.5 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна. Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна.

Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн нэг саналын томьёолол байна.

Төслийг хууль санаачлагчид буцаах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн өөрөө танилцуулчих уу? Тэгье Уянгахишиг гишүүн.

12.30 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь асуудал.

### **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлт**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэллээ. Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Цэндийн Сандаг-Очир хийнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Сандаг-Очир гишүүний юу микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно гэснийг Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэж өөрчлөн найруулсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн холбогдох заалтыг нийцүүлэх шаардлага бий болсон.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гэж заасан бөгөөд уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2020 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Хууль тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний 2.3-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийг 2020 онд багтаан боловсруулах ингэхдээ Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх чиглэлд баримтлахаар заасан. Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын

Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтад хууль тогтоомжийг 2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ боловсруулж, Засгийн газраас 2021 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан. Төрийн байгуулалтын байнгын хорооноос дээрх тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 8/1823, 3 дугаар сарын 31-ний өдрийн 8/2512, 10 дугаар сарын 16-ны өдрийн 10/4381, 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 10/2775, 8 дугаар сарын 20-ны өдрийн 10/7396 дугаар албан бичгийг Засгийн газарт тус тус хүргүүлж байсан болно оо.

Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтож, шийдвэрлэсэн боловч эдгээр хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

Үндсэн хуулийн цэц 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гэж заасны 4 жил гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэснийг зөрчсөн байна гэж дүгнээд мөн өдрөөс 4 жил гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр болсон.

Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхнийг Цэцийн дүгнэлттэй холбогдуулан хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Д.Цогтбаатар:** Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

**Г.Уянгахишиг:** Үндсэн хуулийн цэцийн яг энэ дүгнэлт бол их сонирхолтой гарчихсан дүгнэлт байгаад байгаа юм. Яагаад гэхээр 2019 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Ерөнхийлөгчийн тухай хууль өөрчлөгдөх ёстой байсан. Тэгэнгүүт өнөөдрийг хүртэл өөрчлөгдөөгүй байгаа буюу яг тэн дээр байгаа энэ түдгэлзүүлсэн гээд байгаа заалт маань тухайн үед шууд хүчингүй болсон заалт гэж ойлгож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль Үндсэн хуулиа бариад явчихсан. Тэгэнгүүт тухайн үед одоо ингээд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг харахаар тухайн заалтыг түдгэлзүүлчихсэн гээд байгаа биз. Тэгэхээр тэр заалт чинь хүчинтэй байсан юм шиг ойлголт төрөөд байгаа байхгүй юу. Тэгээд хэрвээ Ерөнхийлөгчийн тухай хуулийн тэр заалт хүчинтэй байсан юм бол 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль яаж явсан байх вэ гэдэг ийм сонин асуудал үүсээд байгаа юм. Тэгэхээр уг нь бол Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсгэх гэхээсээ илүүтэйгээр өөрөөр хэлбэл одоо яг үн хуулийн тодорхой заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх гэдэг маргаан гаргахад тэр хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн заалттай холбоотойгоор маргаан үүсдэг. Гэтэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тэртээ тэргүй тэрэнд нийцээд хүчингүй болох ёстой заалт тийм үү. Засгийн газар тэрийг хуулиа өргөн бариад өөрчлөх ёстой байсан. Үндсэн хуульдаа нийцүүлэх ёстой байсан. Гэтэл тэр үүргээ биелүүлээгүй. Тэр үүргээ

биелүүлээгүйгээс болоод өдий болтол тэр хууль дээрээ явчихсан. Гэтэл тэр хуулийн заалтыг үл хамаараад энэ дунд чинь Ерөнхийлөгчийн сонгууль явчихсан. Өөрөөр хэлбэл яг Үндсэн хуулийнхаа өөрчлөгдсөн заалтаар явчихсан.

Тэгэхээр өнөөдөр Үндсэн хуулийн цэцээс уг нь маргаан үүсгэх гэхээсээ илүүтэйгээр яг энэ заалт бол өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу өөрчлөгдөх ёстой буюу хүчингүй болсон заалт байна. Энийгээ засаж залруул гэдэг зөвлөмжийг ч гэдэг юм уу тиймээ дүгнэлтийг гаргачихсан байсан бол уг нь зүйтэй гэж харагдаад байгаа юм. Тэгэхгүй бол өнөөдөр энэ заалтыг түдгэлзүүлээ гэдэг ойлголт чинь хүчинтэй байсан юмыг түдгэлзүүлж байгаа юм шиг ойлголт гараад ирчхэж байгаа учраас 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль яаж явсан бэ гэдэг энэ асуудал үүсээд байгаа шүү. Тэгэхээр ер нь цааш цаашдаа иймэрхүү юман дээр бид нар анхаарч явахгүй бол одоо яг энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор өөрчлөгдөөгүй хуулийн заалтууд бий. Тэгэхээр тэр бол автоматаар хүчингүй болсон байх ёстой байхгүй юу. Гэтэл хүчингүй болсон гэдгийг илэрхийлэхээс илүүтэй түдгэлзүүлээ гэдэг ийм дүгнэлт гаргаж байгаа бол жоохон хууль зүйн агуулгаараа үр дагавар нь жоохон сонин эвгүй болоод байгаа шүү.

**Д.Цогтбаатар:** Асуулт биш коммент байна гэж би ойлгож болох уу? Би зүгээр энэ дээр нэг зүйл хэлчихмээр байна. Одоо яаж гарсан байхаасаа үл хамаараад Үндсэн хуультай зөрчилдсэн хууль Монгол Улсад угаасаа байж болохгүй шүү дээ. Гарсан мөчөөсөө хүчингүй. Өөрийн чинь тэр хүчингүй гэж хэлээд байгаа яг зөв. Яагаад гэвэл Үндсэн хуультай нийцээгүй бол тэрийг угаасаа дагаж мөрдөх ямар ч боломж байхгүй. Тэгээд түдгэлзүүлэх тухай ч ойлголт байхгүй. Яагаад гэвэл Үндсэн хуультай зөрчилдсэн аливаа хуулийн зүйл заалт түдгэлзээд яваад байна гэдэг ойлголт байхгүй шүү дээ. Тийм тэгэхээр тэрэн дээр ойлголтоо бид нар Үндсэн хуультай зөрчилдсэн л гэвэл тэгээд л хүчингүй шүү дээ.

Сандаг-Очир гишүүн тэрэн дээр тайлбар хэлэх үү? Үндсэн хуулийн цэц юу гэж ярьсан юм. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Тийм тэгээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулиа өөрчилчихсэн. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж бид нар Ерөнхийлөгчийн хуулиа өөрчлөх байсан, нийцүүлж.

Харамсалтай нь одоо өнгөрсөн 5 орчим жилийн хугацаанд ингээд хуулиа өөрчлөхгүй өнөөдрийг хүрч явж ирсэн. Гэхдээ Үндсэн хуультай зөрчилдөж байгаа Ерөнхийлөгчийн тухай хуульдаа бид нар ямар нэг байдлаар нэмэлт, өөрчлөлт хийж нийцүүлж байж хуульд нийцүүлэх ёстой. Гэтэл бид нар энэ хугацаанд ерөөсөө Ерөнхийлөгчийн хуульдаа гар хүрээгүй, засаж залруулаагүй, нийцүүлээгүй явсаар байгаад байна. Сонгууль бол Үндсэн хуулиа бариад явчихсан. Үндсэн хуулиа бариад явчихсан. Тэгэхээр бид нар зайлшгүй Улсын Их Хурал Үндсэн хуультай зөрчилдөж байгаа Ерөнхийлөгчийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж байж нийцүүлнэ.

Тэгэхгүй тэгээд энэ нэг үйлдэл хийгдэхгүй явсаар байгаад өнөөдрийг хүрчихсэн. Дараагийн Ерөнхийлөгчийн сонгуулиа хийх гээд байж байна. Тийм учраас бид нар бол одоо Засгийн газар, Их Хурал аль аль нь л энэ тал дээр буруугаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Нийцүүлэх ажлаа хийхгүй байна. Энэ ганцхан энэ кэйс биш. Өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн цэцийн хэд хэдэн дүгнэлт Сонгуулийн Үндсэн хуультай зөрчилдсэн байна гэдэг дүгнэлтийг гаргаад бид нар хүлээж аваад

нийцүүлээд явж байгаа шүү дээ. Тэрэнтэй адилхан бас яг энэ Сонгуулийн хуультай холбоотой асуудал ингээд явж байгаа. Тийм учраас хүчин төгөлдөр байгаа гэж ойлгож байгаа Уянгахишиг гишүүн гишүүнээ. Ерөнхийлөгчийн тухай хууль одоо болтол. Тэгээд бид нар энийг Үндсэн хуульд нийцүүлж байж сая Үндсэн хуулийн цэц хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа учраас энийг түдгэлзүүлж байна шүү дээ. Тийм учраас бид нар зайлшгүй энэ зүйл заалтыг хүлээн зөвшөөрөөд Үндсэн хуульд нийцүүлж Ерөнхийлөгчийн тухай хуулиа засах ийм асуудал байна.

Тэрнээс Ерөнхийлөгчийн хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа гээд баталчихсан. Тэгээд л шууд Ерөнхийлөгчийн хууль хүчингүй болчихсон гэж ойлгохгүй бол бид нар Ерөнхийлөгчийн хуулиа заавал хүчингүй болгох асуудлыг хийж байж нийцүүлэх ёстой байсан. Энэ үйлдэл хийгдээгүй. Тийм учраас хийгээгүй учраас тэр Ерөнхийлөгчийн хууль одоо хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөөд байгаад байна. Тийм учраас бид нар энийг хүчингүй болгох хуулиа засах ёстой гэдэг ийм л байна.

**Д.Цогтбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Баярбаатар гишүүн байна. Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Яах вэ зүгээр би энэ дээр хэлэх гэж байгаа үг маань зөвхөн энэ хуулийн асуудал биш л дээ. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад сайжруулах гэдэг юм уу Үндсэн хуулийн үзэл санаатай нийцүүлэх ийм хуулиудын төлөвлөгөөг нь улс Улсын Их Хурлаас баталж өгсөн юм. Засгийн газар энэ ажлыг бас тийм сайн хийхгүй байгаа. Би одоо ингээд Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлт тэгэхээр ийм зүйлүүд дээр байнга л асуугаад байгаа юм. Энэ ажлууд хэзээ орж ирэх юм бэ? Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн асуудал бол энэ хуулийн нэг л хэсэг байсан байхгүй юу. Энэ бол зүгээр илэрхий зөрчил байсан. Угаасаа одоо нэг их баримтлаад байгаа ч юм байхгүй. Угаасаа л Үндсэн хуулийнхаа 6 жилээ барина шүү дээ.

Дээрээс нь яах вэ зүгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хуулийг бас төсвийн бодлого дээрээ хориг тавих эрхээсээ эхлээд ер нь зүгээр уучлал үзүүлэх эрхийн процедур ч гэдэг юм уу маш олон зүйлүүдийг сайжруулах ёстой гээд л судлаачид яриад л байдаг үеийн үед л ярьдаг юм. Тэгэхээр уг нь зүгээр Засгийн газар дээр бэлэн төсөл байгаа. Өөрөөр хэлэх юм бол ХЗДХЯ-нд боловсруулж байсан төсөл байгаа. Миний бие өөрөө яг төслийг боловсруулсан хүн байхгүй юу. Тэгэхээр энийг зүгээр ингээд нэг их тийм институц хоорондын үл ойлголцол юм уу ингээд олон нийт зөв буруу ойлгоод байх шиг байна. Энэ дээр нэг их асуудал байхгүй байгаад байхгүй юу. Тэгэхээр уг нь Засгийн газар энэ 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулаад оруулж ирэх ёстой хуулиудынхаа жагсаалтыг шүүж үзээд яаралтай энэ ажлаа л хиймээр байна л гэж. Би зүгээр хэлэх гэсэн юм. Тэгээд энэ ажлуудаа хийгээд явах л ажлын хүрээнд орхигдчихоод байна. Тэгээд энэ орхигдсоноосоо болоод олон нийтэд ингээд л Үндсэн хуульд гар хүрэх гэж байгаа юм байна энэ тэр гээд буруу ташаа мэдээлэл оччихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэд энийгээ анхааръя. Энэтэй холбоотойгоор ер нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль байгаа, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль байгаа,

Цэцэд маргаан шийдвэрлэх тухай хууль байгаа. Ингээд цаашаа явбал Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга байгаа. Тухайн үедээ аргалаад л ерөнхийдөө ойр зуурхан байдлаар л хийчихсэн шүү дээ Даймаа сайдаа. Ашигт малтмалын хууль дээр нөгөө 6.2-ыг бүүр тодруулах Баялгийн сангийн тухай хууль хүртэл сайжруулах юмнууд байна. Ингээд явж байгаа зүйлүүд байх юмаа. Тэгээд уг нь бол тэр төлөвлөгөөг л бид нар нэхэж Засгийн газар шаардмаар байна гэдэг зүйлийг л энд зүгээр протоколын хувьд үлдээх гэж үг авсан юм.

**Д.Цогтбаатар:** Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

**Б.Баярбаатар:** Би бас товчхон санал хэлчихье. Зарим зүйлүүд Сайнзориг гишүүнтэй давхацсан учраас. Ер нь зүгээр бид энэ сая цэцэд итгэмжилсэн төлөөлөгчөөр томилогдсон Сандаг-Очир гишүүн ч хэлж байна. Засгийн газар, Их Хурал бид нар өөрсдөө буруугаа хүлээх ёстой гэж. 2019 онд орсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу өнөөдөр хуулийн зарим хэсгийг ингээд зүйл заалтыг түдгэлзүүлэх асуудлыг 2026 онд яриад сууж байгаа нь аягүй харамсалтай байгаа байхгүй юу. Тэгээд өнгөрсөн 2020-2024 оны парламентын баталж өгсөн Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулийг мөрдөж ажилласныхаа хүрээнд өнгөрсөн оны төгсгөлөөр цэц дээр гомдол маргаан үүсээд нэлээд асуудлыг дагуулаад өнөөдөр манай Булгантуяа тодорхой асуудалд холбогдоод явж байгаа шүү дээ.

Тэгээд энэ мөн л 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу л энэ хууль тогтоомждоо бид нар энэ Үндсэн хуульдаа нийцүүлэхгүй байснаас болж өнөөдөр өөрөө энэ институт хоорондын ийм нэг зөрчил юм шиг ийм нөхцөл байдал үүсгээд байгаа нь өөрөө муу үр дүн үр дагавар гэж л хараад байна. Тэгээд яах вэ ер нь бол Ерөнхийлөгчийн хууль гэлтгүйгээр ер нь бусад хуулиудаа энэ Хууль тогтоомжийн тухай хуулиар бид нар энэ заавал энэ Үндсэн хуулийн зөрчил эсэх гэдгээс үл хамаарч тодорхой хуулийн хугацаанд бид нар энэ үнэлгээ өгч байх ёстой тийм.

Тэгэхээр энэ дээр ер нь өнгөрсөн хугацаанд бид нар тодорхой шалтгаанаар ажиллаж чадаагүй юм болов уу гэж харж байна. Тэгээд сая манай Уянгахишиг гишүүний хэлж байгаа Сандаг-Очир гишүүний хэлж байгаа 2 ийм зөрөөтэй зүйл яваад байна л даа. Үндсэн хууль батлагдсанаар энэ Ерөнхийлөгчийн хуулийн 4 жил гэсэн зүйлээр хүчингүй болчихсон байх ёстой гэдэг нэг агуулга байдаг. Гэтэл энэтэй хууль зүйн процесс нь яваагүй байхгүй юу. Хүчингүй болох процесс нь яваагүй. 1993 оны хууль өнөөдрийг хүртэл ингээд ямар нэгэн үйлдэл хийгээгүй учраас Үндсэн хуулийн цэц өнөөдөр ийм дүгнэлт дээр ийм түдгэлзүүлсэн гэдэг нэг ийм агуулгаар оруулж ирж байгаа нь өөрөө аль аль талдаа эргэлзээтэй байдал үүсэж байна гэж харж байгаа.

Парламент дээр ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй байхгүй юу? Тэгэхээр энэ дээр яг маргалдах хэрэггүй, логик аягүй сонин. Тэгэхдээ бид нар Үндсэн хуулиа л барьж тодорхой түвшинд ажилласан байгаа юм л гэдэг асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ажлын хэсгээ яаралтай байгуул дарга аа. Ер нь энэ Ерөнхийлөгчийн хууль уул нь 1993 оны хуулиа бүхэлдээ шинэчлэгдэх ёстой л гэж би уул нь хараад байгаа юм. Ганцхан зүйл заалтын асуудал биш. Ер нь шинэчилсэн найруулгын түвшинд би энэ Хууль тогтоомжийн хуулиараа энэ 1993 оны энэ нөхцөл байдал өнөөдөр 2026 оны энэ нийгэм, улс төр улс төрийн нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийг харж үзэж бид нар энэ тодорхой асуудлууд дээр энэ хуулийн шинэчилсэн найруулгын асуудал уул нь яригдах ёстой зүйл болов уу гэж би хараад

байгаа. Тэгээд сая бол нийгэмд нэг жоохон тийм тодорхой бус ойлголтууд яг энэ цэцийн дүгнэлт гарахын өмнө явсан. Бараг Үндсэн хуулийн 6 жил гэдэг нь өөрөө буруу ч юм шиг ийм нийгэмд ийм ойлголтыг ялангуяа цахим орчинд нэлээд олон нийтэд хүргэсэн тэгээд энэ нь өөрөө нөгөө иргэдийг төөрөгдүүлэх ийм санаатай, зохион байгуулалттай ийм үйлдлүүд яваад байна уу гэдэг ийм хардлага сэрдлэг бол тухайн үед төрж байсан гэдгийг протоколд үлдээх нь зөв болов уу гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Би энд нэг товчхон ганц зүйл хэлчихье. Нээрээ энэ энэ чинь Хууль зүйн байнгын хороо бололоор бид нар яг аягүй чухал асуудал яригдаж байна шүү нээрээ. Энэ хууль хэрэглээний практикийн асуудал гараад ирж байна. Юу гэвэл Монгол Улсад хууль дээдлэх ёс өөрөө автоматаар хэрэгжээд явж байгаа том эрх зүйн соёл тогтчихсон байгаагийн шинж шүү. Яагаад гэвэл Ерөнхийлөгчийн тухай хууль нь Үндсэн хуультайгаа нийцээгүй байхад Ерөнхийлөгчийн сонгууль явчихсан байгаа байхгүй юу. Энэ чинь одоо ер нь бол төр бо бас нэлээн ийм цалгардсан байдалтай ажиллаж байгаагийн аягүй том илэрхийлэл. Өөрсдөдөө шүүмжлэлтэй хандах ёстой шүү. 2021 оны 6 дугаар сард Засгийн газраар энэ Ерөнхийлөгчийнхөө хуулийг нэмэлт, өөрчлөлт оруулъя гэж шийдвэр гаргачхаад тэгээд оруулж ирээгүй юм байна. Тэгээд тэр чигээрээ явчихсан байна.

Тэгэхээр харин хууль дээдлэх зарчим үйлчилж байгаа нь юун дээр харагдаж байна гэхлээр энэ дээр хэн ч эргэлзэхгүй Үндсэн хуулиа бариад явчихсан байгаа байхгүй юу. Үндсэн хууль бол Монгол Улсын дээд хууль гэдэг нь энэ яг хууль хэрэглээний практик дээр гараад явчихсан. Гэхдээ ийм шийдлээр Ерөнхийлөгчийн сонгууль явагдаад байж ер нь болохгүй. Бид нар тэгэхлээр энэ дээр үнэхээр анхаарч ажиллаж байх ёстой юм байна. Дамдинням гишүүнээ энд санал хураана шүү. Санал хураах гэж байгаа шүү. Ойлголоо ойлголоо.

Тэгэхээр хэдүүлээ энэн дээр нээрээ Хууль зүйн байнгын хороон дээр бол яг энэ асуудлыг сая манай энэ гишүүд Уянгахишиг гишүүн, Сайнзориг гишүүн, Баярбаатар гишүүн ингээд гаргаж ирээд нээрээ тавьж байгаа нь энэ аягүй чухал зүйл шүү. Ингээд одоо энэ чинь харин яг нөгөө яриад байгаа асуудал чинь шийдэх боломж ингээд яг эрх зүйнхээ хүрээнд л гарч ирж байгаа нь энэ.

Гишүүд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан хэлэлцүүлгээ цааш үргэлжлүүлье. Ингээд санал хураалтад бэлтгэе гишүүдээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “4 жил байна” гэж заасны “4 жил” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

### **“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл хаана байна? Тэгвэл ингэе энэ асуудлыг гишүүдээ түр хойшлуулъя тэгэх үү? Тэгэхгүй бол энэ үнэхээр тийм. Би харин ойлгож байгаа. Нэг л хүн оръё гэж байгаа тохиолдолд ингэе. Тэгвэл энэ асуудлыг дараагийн хуралдаан хүртэл хойшлууллаа.

Дөрөв дэх асуудлыг хэлэлцье.

### **Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл сонсох**

**Х.Баасанжаргал:** Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг сонсоно оо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Өвөрхангай аймагт ажиллаж хүүхэд хамгааллын чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан талаарх танилцуулгыг Хүний эрхийн дэд хорооны 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдөр үе хуралдаанаар хэлэлцлээ. Хэлэлцүүлгийн зорилго нь Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлд тусгагдсан хүүхэд хамгааллын тогтолцоонд тулгамдаж буй зарим асуудлыг орон нутгийн түвшинд хүүхдийн оролцоотой хэлэлцэн тодорхойлж, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулахад чиглэсэн болно оо.

Тус хэлэлцүүлэгт Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд ХЭҮК, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Монголын хуульчдын холбооны Өвөрхангай аймаг дахь салбар, ОУБ, иргэний нийгмийн байгууллага, хүүхэд, эцэг эхийн төлөөлөл оролцлоо.

Танилцуулгыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгуулах саналуудыг хэрэгжүүлэхэд ямар хэмжээний зардал шаардагдах, зардлын тооцоолол хийгдсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Өвөрхангай аймгийн хүүхдүүдийн санал нь зөвхөн тухайн бүсийн бус Монгол Улсын нийт хүүхдүүдийн нийтлэг хүсэл хэрэгцээг илэрхийлж байгаа бөгөөд хүүхдийн оролцоог бодитоор хангаж тэдний үзэл бодлыг бодлого шийдвэрт тусгахын зэрэгцээ аймгийн

Засаг даргын үйл ажиллагааг байгаль орчин, хүүхдийн эрхийн хамгаалалт, ажлын байр зэрэг тодорхой шалгуураар үнэлэх. Үүнд:

Хүүхэд хамгааллын бодлогыг тэргүүлэх үзүүлэлт болгох, орон нутгийн түвшинд хүүхэд хамгаалал хөгжлийг бидний асуудал гэсэн хандлагаар авч үзэн зохион байгуулалт, төсөв, санхүүгийн шийдлийг уялдуулах. Мөн хүүхдийн хичээлээс гадуурх хөгжил чөлөөт цагийн боломжийг нэмэгдүүлэх асуудлыг улс төржилгүйгээр шийдвэрлэж, хүүхэд, гэр бүл, нийгмийн салбарын бодлого, хуулиудыг цогц уялдаатай баталж хэрэгжүүлэх. Хүүхэдтэй холбоотой осол, эрсдэлийг бууруулах хүрээнд барилга, зам, дэд бүтцийн байгууллагууд орчны аюулгүй байдлыг чанд хангаж ялангуяа сургуулийн орчинд онцгой анхаарах түүнчлэн суурьшлын бүсэд нохой тэжээхэд тавих хяналтыг чангатгаж хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах талаар асуулт асууж, хариулт авч, байр сууриа илэрхийлсэн болно оо.

Хүний эрхийн дэд хороо уг асуудлыг хэлэлцээд Хууль зүйн байнгын хороонд дараах саналыг хүргэж Улсын Их Хурлын гишүүдийн Улсын Их Хурлын шийдвэрийн төсөлд тусгуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.Монгол Елсын Ерөнхий сайдын жил бүр аймаг НЗД нартай байгуулдаг гэрээнд дараах нөхцөлийг тусгах.

1.Хүүхдийн оролцоонд үндэслэн хүүхэд хамгааллын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог бий болгох эргэх холбоотой байх механизмыг тогтворжуулах, мөн зорилтот бүлгийн хүүхдүүдийн хөгжлийн дугуйлан, чөлөөт цагийн үйлчилгээ, нийгмийн оролцооны хөтөлбөрт түлхүү хамруулах бодлого хэрэгжүүлэх.

2.Хүүхдийн эрхийн асуудлыг зөвхөн нийгмийн хамгааллын салбарын хүрээнд бус орон нутгийн хөгжлийн бодлогын салшгүй хэсэг болгох ач холбогдлыг харгалзан хүүхдийн оролцоонд үндэслэн орчны үнэлгээг тогтмол хийж орчны аюулгүй байдлыг хан хангаж ажиллах. Аймаг сум бүр хүүхдийн орчны үнэлгээг тогтмол хийж эрсдэлийн түвшнээр эрэмбэлэн үүнтэй уялдсан хөрөнгө оруулалт арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх.

3.Иргэний нийгмийн орон зайг бий болгох хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар тусгаж гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт олгох.

2.Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж буй нийгмийн ажилтан хүний нөөцийн сэтгэцийн эрүүл мэнд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, өндөр ачаалал, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа нийгмийн ажилтан алба хаагчдад чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ, чад давтлагажуулах сургалт, зан үйлийн өөрчлөлтийн хөтөлбөрийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх зэрэг болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хүний эрхийн дэд хорооноос гарсан холбогдох саналыг тусгаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг та бүхэнд хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Танилцуулга мэдээллийг та бүхэнд уншиж сонсголоо.

Тэгээд санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасалбар болгоё. Нарантуяа-Нара гишүүнээр тасалбар болгоё. Сайнзориг гишүүний микрофоныг.

**П.Сайнзориг:** Би энэ арга хэмжээг төвийн бүс Өвөрхангай аймагт зохион байгуулаад ирсэн ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье. Ер нь аливаа энэ бодлогын асуудлуудыг зөвхөн Улаанбаатарт төвлөрч биш бүсүүдэд хийдэг энэ хүүхдүүдийн бодит оролцоо дуу хоолойгоо хүргэх энэ бололцоог бид нар бүрдүүлж өгч байгаа нь чухал юм. Тэгээд яах вэ энэ дээр нэг ийм хүүхдийн хэлсэн үг шууд энэ санаанд шууд орж байна. Бааска дарга танилцуулга дээрээ хийхдээ видео шторк үзүүлсэн.

Та хэд энэ саналуудыг бичиж аваад цүнхэндээ хийгээд тэр чигтээ битгий явчхаасай алга болчхоосой гэдэг агуулгаар хүүхэд хэлж байна лээ. Өөрөөр хэлэх юм бол энэ асуудлыг бодит ажил болгоорой. Битгий дүр үзүүлээрэй, хэлбэрдэхээ болиоч ээ, ах эгч нар гэж хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ энэ хүүхдийн асуудал дээр мөн ч их хэлбэрдэж дүр эсгэж ханалаа даа. Тэгээд бодитой тодорхой шийдвэрүүдийг гаргадаг байя гэдэг зүйлийг бид хэд анхаарах ёстой юм. Сая ийм харамсалтай мэдээ сошиал орчинд явж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссоос хэлж байна л даа. 2024 онд 14-өөс доош насны 144 хүүхэд жирэмсэлсэн байна гээд. Энэ чинь шууд цаана нь хайр сэтгэл байсан ч гэсэн нөгөө насны зөвшөөрөл буюу энэ бэлгийн харьцаанд орох насны зөвшөөрлөөсөө бодоод шууд цаана нь хүчингийн гэмт хэрэг явж байгаа байхгүй юу. Бид хэд хүүхдүүддээ хэр их хайртай, хэр их анхаарал хандуулж байгаа нь эндээс л харагдана. Энэ төрийн үйл ажиллагаатай шууд буруу гэж холбохоосоо гадна эцэг эхчүүдийн оролцоо гэдэг чухал. Хаана хаана байгаа вэ гэдэг зүйлийг харж байгаа нэг үзүүлэлт л харагдаж байна.

Тэгэхээр ийм эмзэглүүштэй зүйлүүд явж байна.

Хоёрдугаарт энэ хүүхдийн төлөө гэдэг юм уу ийм зүйл зүйлүүд дээр мэдээж төрөөс бодлогын дэмжлэг үзүүлэх ёстой. Энэ үзүүлж байгаа бодлогын дэмжлэгүүд дээр дандаа улс төрждөг. Одоо 2 жилийн өмнө нэг хүүхдийн соёлын купон зарлах гэсэн чинь бүгдийг нь улс төржүүлсээр байгаад хассан шүү дээ. Энэ хүүхдүүд чинь энийг нэхсэн байна лээ шүү дээ. Бид нарт ингээд цагаа өнгөрөөдөг юм алга. Тэгэхдээ бид хэд ингэж бусдаас хөгжиж суралцаж ийм үйл ажиллагаануудад идэвхтэй оролцмоор байна. Амьдралын янз янзын бололцоотой хүүхдүүд байна гэдгээ бодитой өөрсдөө хэлсэн байна шүү дээ. Тэгээд ингээд төсвийг хэмнэх гэж байна эсвэл тухайн үеийн сайд Соёлын сайд Номин таалагдаагүй юм уу? Ингээд хүүхдийн эсрэг бодлогыг ингээд нулимж хаяж улс төр хийгээд тэрийг энэ асуудлыг чинь бүр жирийтлээ ингээд бүр ингээд барьж гүйгээд явж байсан хүмүүс чинь нэг их гэгээн цагаан хүмүүс болчихсон л явж байх юм. Ерөөсөө л энэ.

Би тэгээд яах вэ зүгээр нэг бүтээлч санал байгаа. Манай Байнгын хороо явах нь зөв болов уу? Энэ гэрийн тэжээвэр амьтны хууль батлагдчихсан. Бид хэд бас энэ хуулийг баталчхаад мартаж болохгүй байна. Энэ хуулийг өнөөдөр хэд дэх жилдээ

хэрэгжиж байгаа юм. 3 дахь уу 3 дахь нь тиймээ? Тэгэхээр энэ хуулийн нэг хэрэгжилтийг дүгнээд ер нь зүгээр энэ нийтийн зориулалттай орон сууц болон.

**Х.Баасанжаргал:** Нэмэлт нэг минут.

**П.Сайнзориг:** Тодорхой. Суурьшлын бүсүүдэд тэжээхийг хориглох гэрийн тэжээвэр амьтан, тэр дундаа нохойны үйлдвэрүүдийг орон нутаг нь шийддэг байх эрх мэдлийг нь энэ тэр гээд өгчихмөөр байгаа юм. Би өөрөө бас нохой тэжээдэг. Боломжтой хэмжээнд бас ингээд айдаг ичдэг гэдэг хүмүүсүүдээс л эвтэйхэн лифтэндээ суухыг л хүртэл хүсдэг байхгүй юу. Гэтэл сүүлийн үед нийтийн зориулалттай орон сууцанд том том воркинг дог буюу мастип төрлийн нохойнууд дээрээс нь Кавказ төрлийн нохойнуудыг тэжээж байна. Энэ хүн амьтан баривал дийлдэхгүй бас. Тэгэхээр энийг уг нь хязгаарладаг л асуудал байдаг. Энийг хүүхдүүд бүүр илүү их гаргаж ирсэн байна лээ шүү дээ. Ер нь энэ хараа хяналтгүй нохойноос гадна энэ орчин тойрондоо аюул учруулж болох энэ амьтнаас дандаа айж явдаг. Энийг анхаарч өгөөч. Энийг шийдвэрлэдэг болгож өгөөч гэдэг зүйлүүдийг хүүхдүүд маань хүүхдүүд маань өөрсдөө хэлээд байгаа шүү.

Тэгэхээр бид хэд энийг ингээд жижиг гэлтгүй л асуудлуудыг анхааръя тэгээд тэр хуулийн нэг хэрэгжилтийг нэг дүгнэж сонсож үзвэл яасан юм бэ гэдэг ийм санал байна. Баярлалаа.

**Х.Баасанжаргал:** Нарантуяа-Нара гишүүний микрофоныг өгье.

**М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд хүргэе. Манай хүний эрхийн дэд хороо Өвөрхангай аймагт маш амжилттай ажиллаад яг хүүхдүүдтэй нэг бүрчлэн уулзаад тэдний санал санаачилга, санал бодол, асуудал бэрхшээлийг өөрсдийнх нь амнаас сонсоод ирсэнд маш талархалтай байна. Тэгээд энэ юун дээр нөгөө Ерөнхий сайдын жил бүр Засаг дарга, НЗД нартай байгуулдаг гэрээнд тусгах юунууд дээр ялангуяа энэ аймгийн Засаг даргууд болон сумын Засаг даргуудыг ч гэсэн оруулж өгмөөр юм билээ. Жишээлбэл одоо энэ нөгөө нэг эцэг эх нь бас яг хүүхдүүдээ хайхарч чадахгүй байгаа үл хайхрах хүчирхийлэлд өртдөг хүүхдүүд давхар нийгмийн маш олон олон асуудалд өртөж нэмж хүчирхийлүүлдэг асуудлыг авч хэлэлцэхгүй бол болохгүй болчихсон байна. Хүн харахад ээж аавтай гээд байгаа юм. Эмээ, өвөө нь харж байгаа гээд байгаа юм. Тэгсэн мөртөө ингээд яг асран хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байгаа, харж хандаж чадахгүй байгаа тэр байдлаасаа болоод 4 сарын 18-нд энэ дөнгөж тавхан нас сурч байгаа хүүхдийг энэ уяачид хүлээд моринд хүлээд давхиулчихсан байна шүү дээ. Тэгээд одоо үхлүүт хэвтэж байна. Хөх хот руу юу ч гэсэн аваад явъя гээд уяачид нь ярьж байгаа юм байна.

Тэгээд бид нар нэг ингээд л жил болгон ингээд л асуудал бэрхшээлийг урьдчилж үнэлж, дүгнэж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх гээд л хөрөнгө, мөнгө төсөв ард түмний татварын мөнгөнөөс ингээд л яваад байдаг. Гэтэл яг бодит байдал дээр хэрэгжиж байгаа зүйл ерөөсөө байхгүй. Тэгээд ингээд мөнгө урсгаад байдаг хэрэгжиж байгаа зүйл байхгүй байхаар бид нар энэ нэг арга аргачлалаа өөрчлөх ёстой юм юм байна л гэдгийг харуулаад байна л даа. Тэгээд ХЭҮК-оос тавьж байгаа юманд болохоор зэрэг ер нь энэ Нийгмийн хамгааллын яамнаас тавьж байгаа юманд нийгмийн ажилтнууд хүрэлцэхгүй байна.

Дээрээс нь тэд нар ажлын ур чадвар дутмагшилтай байна. Туршлагажих болон мэдлэг боловсруулах илүү боловсронгуй болгох тэгээд дээрээс нь цалин хөлсний асуудал яригдаж байна. Тэгэхээр зэрэг энэ дээр бид нар дахиад л шат ахисан өөр юм бодохгүй бол. Ингээд нөгөө хэрэг үүссэн хойно нь бид нар хэргийн араас явах биш хэрэг яаж үүсэхгүй байх тухай асуудалд мөн түүнчлэн хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээхээд хүлээж чадахгүй байгаа тэр үүрэг хариуцлагаа хүлээгээгүй хүмүүст хариуцлага тооцдог энэ механизмыг бүрдүүлэхгүй бол ингээд их хэнэггүй байна Монголчууд. Хүүхдээ ингээд үхлүүт болгочоод л тэгээд л ингээд л төрөөд л байдаг, төрөөд л байдаг захаас нь авхуулаад төрсөн хүүхдүүдээ ингээд хөдөө хээр хаа нэгтээ эмээ, өвөөд ингээд хаячихдаг. Эмээ өвөө нь ч асарч халамжилсан юм байхгүй. Ингээд хүүхдийн амь нас эрүүл мэнд дээсэн дөрөөн дээр байгаа явдлууд үнэхээр манай Монгол Улсын том эмгэнэл болж байна.

Тэгэхээр бид нар ялангуяа энэ ээж аав нь хайхарч байгаа хүүхдүүд нэг хэрэг байна. Ээж аав нь ч хайхрахгүй, эмээ өвөө нь ч хайхрахгүй нэг ийм хэн ч хайхрахгүй. Одоо жишээлбэл өнгөрсөн.

**Х.Баасанжаргал:** Нарантуяа-Нара гишүүний микрофоныг нэг минут нэмж өгье.

**М.Нарантуяа-Нара:** Сэлэнгэ аймагт ч гэсэн 13 настай охиныг асран хамгаалах хүн байхгүй гэдгээр цагдаа нарт хүчирхийлүүлсэн гээд л асуудал яригдаад л яваад л ингээд л дууссан. Ингээд ар араасаа яг ийм хүүхдүүдийг илүү их онилж энэ хүүхдүүдийг эрүүл мэнд, амь насыг нь хөсөр хаях энэ үзэгдлүүдийг л бид нар аягүй сайн авч хэлэлцэх ёстой юм байна. Тэгэхгүй бол нэг талаараа ээж аав нь, эмээ өвөө нь хариуцлагатайгаар харж хандаж байгаа хүүхдүүд шал өөр нөхцөлд байна. Гэтэл тэрнээс хүн харахад ээж аав нь байгаа, эмээ, өвөө нь байгаа. Тэгсэн мөртөө дунд нь орхигдоод байгаа энэ хүүхдүүдийг яах вэ гэдэг асуудал дээр аягүй фокуслах хэрэгтэй болсон юм байна гэж харж байна.

**Х.Баасанжаргал:** Баярлалаа. Тэгээд би сая Сайнзориг гишүүний хэлсэн дээр яг тэр нөгөө Гэрийн тэжээмэл тэжээвэр амьтны тухай хуулийн хэрэгжилт дээр яалт ч үгүй нэг анхаарахгүй бол болохгүй байгаа. Яагаад гэвэл хүүхдүүдээс энэ санал маш их гарсан. Хамгийн их орчинд нь айлгадаг зүйл. Орчиндоо аюулгүй зорчиход хамгийн их бэрхшээл учруулдаг зүйлийн нэг нь бол яалт ч үгүй энэ эзэнгүй нохой, муур.

Дээрээс нь эзэнтэй мөртөө яг хүүхдүүдийг хичээл тарах цагаар, хүүхдүүдийг хичээлдээ явах цагаар нохойгоо ингээд сул тавьчихдаг айлууд байна гээд. Тэгэхээр үүнийг яг ингээд орон нутаг өөр өөрсдийнхөө онцлогт тохируулсан байдлаар хуульд гарчихсан. Миний санаж байгаагаар бол хуулиараа бол орон нутаг өөрөө тохирсон арга хэмжээгээ авах ийм чиг үүрэг нь байгаа. Тэгээд үүн дээр бол үнэхээр хайхрамжгүй хандаж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Хоёрдугаарт саяын Нарантуяа-Нара гишүүний ярьсан тэр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоон судалгаа, мэдээлэл, тэд нарт зориулсан үйлчилгээ тасралтгүй байх, тасралтгүй хяналтын асуудал бол үнэхээр яг тулгамдсан асуудал болоод байгаа. Бид нар энэ нөгөө хэрвээ та бүхэн маань батлах юм бол аймаг орон нутгийн удирдлагуудад үүрэг болгож байгаа нь аймгууд, орон нутгууд өөрсдөдөө тохирсон төлөвлөгөө гаргаачээ. Хүүхдүүдээ сонсооч ээ.

Хүүхдүүдийн оролцоон дээр тулгуурлаад та нарт юу болоод байна, юу болохгүй байна гэдгийг нь сонсоод яг төлөвлөгөөгөө яг орон нутагт өөрт нь тохирсон байдлаар энэ үйл ажиллагаагаа төлөвлөөч гээд байгаа юм. Бүгд нөгөө дээрээс доошоо чиглэсэн байдлаар биш. Дээрээс заавал нэг заавар хүлээдэг байдлаар биш. Тэгэхээр яг энэ орон нутгийн хүүхдүүд өөрсдөө маш олон сонирхолтой саналууд хэлж байгаа байхгүй юу. Дээрээс нь хүүхдүүд маш бүтээлч байна. Саналаа хэлэхээс гадна шийдлийг хүүхдүүд танилцуулж байна. Одоо жишээ нь гудамжинд бүх гудамжинд гэрэл тавь гэхгүй. Өндөрлөг хэдэн газрууд нь том гэрэл асаачхаач та нар мөнгө нь байхгүй байгаа гээд. Ингээд хүүхдүүд аягүй бүтээлч санал хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр эдгээр орон нутгуудын хувьд бол өөрсдөө гэхээс илүү хүүхдүүдийн оролцоон дээр тулгуурлаад энэ санал төлөвлөгөөгөө боловсруулдаг, түүнийхээ хэрэгжилтийг хянадаг, үнэлдэг, ийм байх талаас нь энэ гэрээнд бол заалт оруулж байгаа юм гэдгийг хэлэх гэсэн юм.

Тэгээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Дараагийнхаа асуудлыг хэлэлцээд эхэлж байя. Тэгээд санал хураалтыг дараагийнхаа санал хураалтыг хэлэлцэх үеэр санал хураалтаа нэг явуулъя гэж бодож байна.

Хэлэлцэх асуудлын 5.

### **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 илтгэл**

Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэж эхэлнэ.

Монгол Улсын ХЭҮК-оос 2026 оны 3 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг та бүхэнд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Илтгэл хэлэлцэх албан тушаалтнуудыг оруулж ирэхийг урья.

2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 11 цаг.

Монгол Улс дахь хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг танилцуулах албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Дугарын Сүнжид ХЭҮК-ын дарга, Хүрэлбаатарын Мөнхзул ХЭҮК-ын гишүүн, Ганбатын Нарантуяа ХЭҮК-ын гишүүн, Жаргалсайханы Хунан ХЭҮК-ын гишүүн, Батзэвэгийн Энхболд ХЭҮК-ын гишүүн, Цангишаравын Дондов ХЭҮК-ын гишүүн, Тогоохүүгийн Ихтамир ХЭҮК-ын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хишгээгийн Цэцэгээ ХЭҮК-ын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга, Галбадрахын Ууганбаатар ХЭҮК-ын Гомдол, Хяналт шалгалтын хэлтсийн дарга, Сандагийн Тунгалагтамир ХЭҮК-ын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Сүрэнжавын Ганзориг ХЭҮК-ын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга, Батдэмбэрэлийн Эрдэнэбат ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга, Доржийн Ёндонжамц ХЭҮК-ын орон нутаг хариуцсан дарга.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийн талаарх товч танилцуулгыг Монгол Улсын ХЭҮК-ын дарга Дугарын Сүнжид танилцуулна. 3 дугаар микрофоныг өгөхийг хүсье.

**Д.Сүнжид:** Хууль зүйн байнгын хорооны гишүүд, та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл 6 сэдвийн хүрээнд боловсруулагдсан.

Нэгдүгээр сэдэв эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх байгаа.

Энэ хүрээнд олон улсын конвенц баримт бичигт заасны дагуу 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, хүрэлцээ, чанар, нийцтэй байдал, санхүүгийн хамгаалалт гэдэг ийм 5 шалгуур үзүүлэлтээр авч үзлээ.

Энэ дээр бид нар хүрэлцээ хүртээмж, чанар нийцтэй байдлын санхүүгийн хамгаалалтын хувьд аль алин дээр нь анхаарах асуудал байна гэдгийг тоо бүрийн статистик дээр дүгнэсэн. Тухайлах юм бол орчны хүртээмж, үйлчилгээний хүртээмж, мэдээллийн хүртээмж гээд аваад үзэхээр аль алин дээр нь дутагдалтай сайжруулах ёстой асуудлууд байна. Хот, хөдөөгийн нөхцөл байдлаас хамааралтай зорилтот бүлгийн эрүүл мэндийн тусгай ийм хэрэгцээ онцлог үйлчилгээнээс хамааралтай зэрэг ийм асуудлууд байна гэдгийг дүгнэж байгаа. Хүртээмжийн хувьд мөн ялгаагүй. Ялангуяа эмийн нөөц энэ тоног төхөөрөмжийн хүрэлцээ орчны нөхцөл гэдэг дээр энэ дүгнэлтийг хийсэн. Түүнээс гадна чанар дээр чанар нийцтэй байдал дээр бол ер нь халдваргүйжүүлэлт гэдэг дээр 50 хувь бол энэ анхаарах асуудал байна гэдэг ийм дүгнэлт гарсан. Мөн түүнээс гадна энэ санхүүгийн хамгаалалт буюу ЭМД өглөг авлага энэ хүнээс гарч байгаа. Иргэнээс өөрөөс нь гарч байгаа зардалтай холбоотой асуудлыг анхаарах шаардлагатай. 2022 оноос хойш хэрэгжүүлж байгаа тогтолцоог ахиц дэвшилттэй тогтолцоо мөн боловч өмнө нь ковидын үеэс хойш хуримтлагдсан өглөг авлага нь дуусаагүй, эрүүл мэндийн байгууллагууд ялангуяа анхан шат дээр байнга өглөг авлагатай байгаа учраас зарим хэмжээнд бол их өөрсдийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсийг тавьж чадахгүй хүртэл хэмжээнд очсон байна.

Тийм учраас энэ 80, 20-ийн санхүүжилт болон квотын асуудлуудыг эргэж харах өглөг авлагыг дуусгах асуудлыг шийдэх нь зүйтэй гэдэг ийм саналыг өгсөн. Эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт дээр энэ системийг цоо шинээр хийхгүй бол болохгүй байна. Хяналт, чанарын асуудал, үнийн асуудал гээд энэ асуудлууд тасрахгүй үргэлжилж байна. Энэ дээр зөрчлийн тоо гаалийн болон эмийн хяналтын агентлагаас авсан мэдээллээр үзэхэд зөрчлийн тоо өндөр тоотой ийм дүн байна. Энэ сэдвийн хүрээнд эмч, эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрх гэдэг асуудлыг мөн авч үзсэн. Энэнтэй холбоотой Засгийн газрын 11 11 төв дээр бол 25 мянга орчим гомдол мэдээлэл эрүүл мэндийн салбартай холбоотой ирсэн байна. Өөрсдөө эмч, эрүүл мэндийн ажилтнуудаасаа бас энэнийхээ 10 хувьтай тэнцэх гомдол мэдээлэл ирж байна. Хамгийн их иргэдээс ирүүлж байгаа гомдол мэдээлэл бол эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой байгаад байгаа юм. Мөн түүнчлэн эмч эрүүл мэндийн ажилтны ийм хандлага харилцаатай холбоотой асуудлыг

хамгийн их хөндсөн байна. Хүлээлэгтэй холбоотой асуудлыг дараа нь хөндсөн байна. Аж ахуй үйлчилгээтэйгээ холбоотой асуудлыг.

Харин эмч, эрүүл мэндийн ажилтнуудын хувьд бол өөрсдөө ажлаа сайжрах хам шинжийн асуудал, цалин хөлсний асуудал, хөдөлмөрлөх орчин нөхцөлийн асуудлыг хөнджээ. Энэ 1 дүгээр сэдвийн хүрээнд мөн эрх зүйн давхардал, хийдэл, зөрчлийг авч үзсэн. Ингээд 116 давхардал, хийдэл, зөрчил байна. Үүнийгээ сайжруулах ёстой гэдгийг нь санал болгож дүгнэлтдээ оруулсан. Удирдлагын хувьд бас тогтвортой байдлыг хангах үүднээс ТУЗ, ЭМД-ын Үндэсний зөвлөл зэрэг энэ тогтолцооны хувьд анхаарах асуудал тогтвортой ажиллуулах дээр шинэчлэл хийх ёстой гэдэг дүгнэлтийг өгсөн. Төрийн өмчийн 51 байгууллагын 13-д нь ТУЗ байгуулсан байдалтай, бусад нь байгуулаагүй байнгын ийм маргаантай явж байдаг ийм тогтолцоо байгаа учир удирдлагын тогтвортой байдал гэдэг анхаарах асуудлын нэг болжээ.

Санхүүжилтийн хувьд ДЭМБ-аас 25 хувь ер нь өрхөөс гарах ёстой болж байна гэж үздэг юм байна. Тэгтэл энэ хувь нэг дахин өссөн гэдэг үзүүлэлтийг бид нар хэлж байгаа. Өөрөөр хэлбэл эмэнд зарцуулж байгаа байдал, тэр бусад туслах хэрэгсэл мөн давхар хэрвээ орон нутгаас ирж үйлчилгээ авбал давхар бусад зардлууд, дагалдах зардлууд, өрхийн гишүүний бусад зардал гээд ингээд нэмэгддэг. Ийм дарамт болдог байдал ихэссэн байна. Мөн гадаадад үйлчилгээ авах байдал ихэсчхээд хэдийгээр дотооддоо эмчлүүлэх боломжтой гэж оношлогдсон боловч 2 хүн тутмын нэг нь өөрсдийнхөө хүслээр гадаадад оношилж эмчилсний гээд илүү дээр гэж үзсэн ийм нөхцөл байдалтай байна. Ингээд энэ 1 дүгээр сэдвийн хүрээнд нийтдээ 18 саналыг Улсын Их Хурлын тогтоолд оруулахаар өгсөн.

Хоёр дахь сэдвийн хүрээнд шүүх шинжилгээ ба хүний эрх гэдэг энэ сэдвийн хүрээнд нөгөө шударгаар шүүлгэх эрхтэй нь холбоотой юм. Тэгээд шинэ шүүх шинжилгээний байгууллага бол энэ мөрдөн шалгах ажиллагааны явц, шударга шүүхээр тодорхой төрлийн гэмт хэргийг шийдүүлэхэд ялангуяа 4 төрлийн гэмт хэрэгтэй холбоотой энэ амь нас, эрүүл мэнд бэлгийн хүчирхийллийн асуудлыг яг энэ шүүх шинжилгээний байгууллагын гаргасан дүгнэлтэд үндэслэдэг. Гэтэл энэ дээр хүний нөөцийн асуудал урвалж, тэр бодисын хангалт, хүрэлцээ, машины асуудал, орчин нөхцөлөөс шалтгаалаад энэ шүүх шинжилгээний байгууллага дээр анхаарах ёстой асуудлууд байна. Эцэстээ нөгөө хугацаа нь удааширдаг. Хийх ёстой шинжилгээний дүгнэлт нь хугацаандаа ирдэггүй, эсвэл урвалж химийн бодис байхгүйгээс хадгалах нөхцөлийг бид нар хангаж чадахгүй байна гэдэг ийм нөхцөлийг байдалтай байгаа. Өөрөөр хэлбэл энэ салбарыг ер нь бол цогцоор нь анхаарахгүй бол их хаягдсан дайвар байдалтай явж ирсэн юм байна гэдэг нь энэ барилга байшин, хүний нөөц, туслах хэрэгсэл, энэ бодис хангалтын байдлаас харагдаж байгаа. Энэ дээр нь нийтдээ 11 дүгнэлтийг гаргуулахаар өгсөн. 3 дахь сэдвийн хүрээнд олон нийтийн мэдэх эрх гэдэг ийм сэдэв байгаа. Тэгээд олон нийтийн мэдэх эрхийн хүрээнд бол мэдээлэл хайх хүлээн авах эрхтэй гээд. Бид нар энэ 2021 онд 5 хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Ингээд индексийг харахаар бид нар сайжирч байгаа дүр зураг харна. НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн индекс 2020 онд 92 байсан бол 2024 онд 46 болжээ гэхчлэн ийм тоон үзүүлэлтээр бол сайжирсан үзүүлэлт харагдаж байгаа. Тэгэхдээ чанарын хувьд аваад үзэхээр нөгөө нээлттэй байх ёстой мэдээллүүдийн чинь түүвэр байгууллагуудын 37 хувь нь л ил байна нийтэд ил тод байна. Бусад нь хүсэлт гаргаж авах ийм хэмжээний байна гэхчлэн ийм ийм асуудлууд байгаа. ХЭҮК-т байнга удаа дараа төрийн байгууллагууд нээлттэй нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн дагуу нээлттэй байх

мэдээллийг л ойлгохгүй байна. Тэгээд хүсэлт гаргаад ч өгөхгүй байна гэдэг асуудлаас ийм гомдол ирдэг. Ингээд үзэхээр тоон ахиц байгаа боловч хэрэгжилт дээр бид нар энийгээ хэрэгжилтийн агуулга яг сэдвээ хангах шаардлагатай байна гэдгийг илэрхийлсэн.

Мөн түүнээс гадна Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төсөлтэй танилцаад одоо байгаа хэрэгжиж байгаа хуульд нуух шаардлагагүй ийм асуудлуудыг оруулсныг хуулийн төсөл дээр заримыг нь гаргана гэдгийг сайшаасан. Тэгэхээр хууль тогтоомжийн хувьд нийцүүлэх асуудал байгаа. Мөн агуулга энэ хандлагын хувьд бодит байдал дээр энэ ил тод байдлаа хангах хэр хэрэгтэй байгаа гэдгийг илэрхийлээд нийтдээ 6 саналыг энэ хүрээнд өгсөн.

Дөрөв дэх сэдэв хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтээр.

2021 онд энэ хуулийг баталсан. Түүнээс хойш жил бүр энэ хүрээнд бид сэдвийн дагуу Улсын Их Хуралд илтгэж байгаа. Энэ удаа хүний эрх хамгаалагчийн хамгааллын талаар төрийн байгууллага ер нь үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ гэдэг дээр голлож дүгнэсэн. Тэгэхээр энэ дээр сайн тал нь энэ хуулийн талаар сонссон. Ялангуяа иргэний нийгмийн байгууллагын хүний эрхийн активистууд түүнчлэн төрийн байгууллагуудаас ч гэсэндээ хүний эрх хамгаалагч гэдгийн талаар ойлголтыг мэдчихсэн байна гэдэг бараг 100 хувь шахуу ийм мэдсэн байна гэдэг ийм сайн талтай. Харин хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг хүмүүсээс өөрсдийгөө 2 хүн тутмын нэг нь аюулд өртдөг, заналхийлэлд өртдөг, эрсдэлтэй нөхцөлд ажилладаг гэдэг ийм зүйлийг хэлж байгаа.

Тийм учраас цаашдаа энэн дээр сайжруулах зүйл байна гэж үзээд 6 саналыг Улсын Их Хуралд өргөн барьсан. Өмнө гаргаж байсан хүний эрхийн хамгаалагчийн гэрч хохирогчийг хамгаалах тэр сэтгэл зүйн болон бусад нэн яаралтай гомдол гаргасан этгээдэд хүний эрх хамгаалагчид тусламж үзүүлэх шаардлагатай фонд ийм санхүүжилтийг бий болгох асуудал ч гэсэн давтан орж байгаа гэдгийг энэ ташрамд танилцуулъя.

Тавдугаар бүлгийн хүрээнд хүүхэд хамгааллын тогтолцооны анхаарах асуудал дээр 10 байгууллагуудыг авч үзсэн юм.

Тэгээд энэ байгууллагуудын үйл ажиллагаа чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байгаа вэ гэдгийг дурдсан. Энэ дээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл байгаа, орон нутгийн зөвлөл байгаа, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо бий. Түр хамгаалах байрууд байна. Гэр бүл нийгмийн ажилтнуудын тухай, мөн байцаагч нар, хууль ёсны төлөөлөгч, шинжээчид, хамтарсан баг гээд энэ 108 хүүхдийн шуурхай тусламж хамгааллын төв гээд нийтдээ 2105 ийм нэгжийг авч үзсэн байна. Энэ хүрээнд хийх ёстой ажил нь 1 дүгээрт хууль эрх зүйн хүрээнд нийцүүлэх ёстой асуудал гаргачихсан журам дүрмийн хуульд заасан захиргааны хэмжээний актаа зохих ёсоор гаргах тухай асуудлыг, хоёрт нь бол энэ үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын хоорондын мэдээллийн сан зөрөөтэй. Тэгэхээр мэдээллийн сангаа нэгтгэх асуудал төсөв санхүүгээ нэгтгэх асуудал шийдвэрлэх тухай асуудал байгаа.

Мөн түүнчлэн он удаан жил дандаа яригдаж байгаа давтан давтан яригддаг нэг асуудал энэ уялдаа холбоо нэг зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхтэй харилцан уялдаатай байж чадахгүй байна. Тийм учраас энийгээ сайжруулах ёстой гэдэг энэ

зөвлөмжийн хүрээнд нийтдээ 11 саналыг Улсын Их Хуралд танилцуулсан. Сүүлийн бүлэг нь жендерийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд эрэгтэйчүүдийн эрхийг авч үзсэн. Тэгээд 3 асуудал дээр илүү төвлөрсөн. Ер нь нөгөө жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нь 11 хүрээ байдаг. Тэндээс бид нар 3-ыг нь эрэгтэйчүүд дээр доголдож байна буюу анхаарах ёстой тусдаа Засгийн газар. Хөтөлбөр төлөвлөгөө гаргах ёстой. Нэг нь бол эрүүл мэндийн асуудал байгаа. Зөвхөн дундаж наслалтын зөрөө төдийгүй ер нь тэр амбулаториор үзүүлж байгаа тоог харахаар нэг дахин ялгаатай байдаг ийм үзүүлэлт байна хамгийн хүндэрсэн архаг цочмог ийм болсон үедээ эрэгтэйчүүд илүү эмнэлэгт ханддаг гэдэг ийм дүр зураг байгаа учраас урьдчуу таслан сэргийлэх чиглэл рүү анхаарах ёстой.

Тэгээд эрүүл мэнд дундаа ахиад нэг асуудал яригдаад байгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал нухацтай авч үзэх шаардлагатай болсон байна.

Хоёр дахь асуудал нь хөдөлмөрлөх боловсролын салбар дахь асуудлууд байгаа. Боловсролын салбарт өмнөх өмнөх илтгэлүүд ч гэсэн мөн дурдаж байсан. Тэгэхдээ Засгийн газраас тухайлан арга хэмжээ эрэгтэйчүүдэд зориулж аваагүй болохыг энд тэмдэглэе. Анх СӨБ болон ЕБС эхлэхэд 1, 1-ийн харьцаатай эхэлдэг ч гэсэн бүрэн дээд боловсрол дээрээ очихоор энэ зөрүү эрс ихэсдэг. Мөн түүнчлэн сургуулиас завсардаж байгаа хүмүүс нь эрэгтэйчүүд байдаг. Энийг олон жилийн тоо статистик харуулдаг боловч үүнд чиглэсэн тодорхой арга хэмжээ авсангүй.

Гурав дахь асуудал нь энэ хөдөлмөрлөх эрхийн чиглэл дээр бол энэ хөдөлмөрийн аюулгүй байдал.

**Х.Баасанжаргал:** 3 дугаар микрофоныг нэмж өгье.

**Д.Сүнжид:** Гурав дахь энэ эрчүүдийн эрхийг хамгаалах асуудал дээр хөдөлмөрлөх эрх байгаа. Энэ юунаас биш өвчнөөс биш, хөгшрөлтөөс биш ийм цаг зуурын шинжтэй нас барж байгаа, амь насаар эрсэдэж байгаа эрүүл мэндээрээ хохирч байгаа байдал эрэгтэйчүүд дээр давамгайл. Тэгээд энэ тоон үзүүлэлтийг нь харахаар бараг заримдаа ийм зөрчилтэй мөргөлдөөнтэй улс шиг ийм хэмжээний амиа алдаж байгаа дүр зурагтай байгаа учраас энэ хэсэг дээр тэр стандартыг сахиулах ХАБ-ыг нь сахиулах хөдөлмөрийн байцаагч нарт зохих тэр эрх бүхий байгууллагууд ажиллаа зохих ёсоор гүйцэтгэх урьдчилан сэргийлэх зайлшгүй хэрэгтэй байна.

Эцэст нь эрэгтэйчүүд дээр 3 зорилтот бүлгийг авч үзсэн. Гэр оронгүй тэнэмэл иргэдийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн асуудал, орон нутаг дахь буюу малчин эрэгтэйчүүдийн асуудал тоо статистикаас үзэхэд энэ эрчүүдэд зориулсан тодорхой улсын дэмжих, иргэний оролцоо, нийгмийн харилцаанд оролцох байдлыг нь дэмжих ийм шаардлагатай байна гэж үзсэн 3 бүлэг илэрхийллээ.

Энэ хүрээнд 6 саналыг өгсөн. Ингээд нийтдээ ХЭҮК-оос 25-д илтгэлийн 6 сэдвийн хүрээнд 60 саналыг Улсын Их Хуралд, Улсын Их Хурлын тогтоолд оруулахаар санал гаргаж байгаа болно оо.

Ингээд асуулт байвал хариулахад бэлэн байна. Танилцуулга дууслаа.

**Х.Баасанжаргал:** Сүнжид даргад баярлалаа.

Санал дүгнэлттэй холбоотой, илтгэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Цэнгүүн гишүүнээр тасалбар болгоё. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл ирлээ.

6 сэдвийн хүрээнд бэлдсэн юм байна. Уг нь чухал 6 сэдэв байдаг. Танхимд маань Баасанжаргал, Уянгахишиг, Цэнгүүн гээд дөрвүүлхнээ сууж байна даа. Ийм байдалтай бид нар хүний эрхийн асуудал дээр хандаж байна. Хүний эрхийн мэдрэмж ийм л байна. Бүгд их амаараа гоё ярина, бүгд хэлбэрийн. Тэгээд энэн дээр нэг тогтоод суугаад ядаж сонсчих ёстой шүү дээ. Яах вэ нэг давуу тал байгаа. Энэ зөвхөн ХЗБХ хэлэлцэгдээд дуусах биш, Улсын Их Хурлын чуулган руу орно. Тэгээд чуулган дээр орохоор идэвхтэй гишүүд байгаасай л гэж хүсэж байна.

Нэгдүгээрт яах вэ би протоколын хувьд өгөөд Байнгын хорооны санал, дүгнэлтэд энэ асуудлыг тусгаж өгөөсэй гэж хүсэж байгаа шүү. Хурал даргалагч анхаарна биз. Засгийн газрын яг энэ хүний эрхийн төлөв байдлын тайлантай холбоотойгоор Засгийн газрын болоод Засгийн газрын гишүүд, тэгээд холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл заавал оролцдог баймаар байна. Энд юм яриад байдаг, тэнд яг хэрэгжүүлэх гэдэг юм уу тодорхой тэр төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа төсөв мөнгийг нь тавих эсвэл зохион байгуулалт дэд бүтцийн дээр нь анхаарч байгаа хүмүүс чинь ерөөсөө ойлголтоггүй байна шүү дээ.

Тэгээд ерөөсөө ингээд нэг ийм формал.

Дээрээс нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлуудыг хүний эрхийн энэ тайлантай уялдуулж тухайн жил ямар ямар хууль тогтоомжийн хэрэгжилтийг сонсох вэ гэдэг зүйлүүдийг эднүүдтэй уялдуулмаар байна. Тэгээд энэ чинь ингээд тал талынхаа нөгөө хэдүүлээ нөөц гэдэг юм уу энэ хүчин чармайлтуудаа нэгтгэх гээд байна шүү дээ. Энд ийм зузаан юм хийгээд ирээд байдаг. Бид хэдийн нэг энэ ерөөсөө хальт сонссон болоод өнгөрчхөөд байна. Энийг нь ахиулаад Улсын Их Хурал ийм бодлогын тогтоол болгож чиглэл өгөхөөсөө гадна яг энэ нийтийн мэдээллийн ил тод байдал, ил тод байдлыг хангаж байгаа чиглэлийг бүх хуулиудыг нь сонсчихмоор байна. Хүүхдийн эрхийн чиглэлийг хуулиудыг нь сонсчихмоор байна. Хэрэгжилт нь яг яаж байна. Засгийн газрын байр суурь нь юу юм? Тэгээд энэ хүний эрхийн комиссын тайлантайгаа уялдуулж авч үзээд хаанаа бид хэд ойлголт нэг байгаа юм. Хаанаа зөрөөд байгаа юм. Хаанаа аль асуудлуудаа яаж цэгцлэх юм гэдэг юмаа ингээд шийдчихдэг баймаар байна.

Энд их үнэтэй ажил хийгээд ирэхэд бид хэд авч хэлэлцэхгүй байж байгаад дараа нь бараг энэ ажлыг ингээд л бүр тооны хувьд утгаа алдчихсан эсвэл жоохон ач холбогдол буурчихсан хойно нь бүгд санасан юм шиг яриад л эш татаад л. Тэгэхээр бид хэдийн энэ цаг цаг тухайд маань асуудлыг шийддэг энэ зүйл рүү явмаар байна. Энийг бүр Байнгын хорооны санал, дүгнэлтэд оруулж өгөөч. Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулмаар байна. Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулмаар байна. Энийг хэлэлцэхэд Засгийн газрын гишүүд, Монголбанк ч байдаг юм уу холбогдох тэр төрийн институцүүд нь баймаар байна.

Тэгээд энэ тухайн жилдээ Улсын Их Хурлын хэрэгжилтийг нь сонсдог хууль тогтоомжтой уялдуулж энэ сэдвийг уялдуулж.

**Х.Баасанжаргал:** Сайнзориг гишүүний микрофоныг нэг минут нэмж өгье.

**П.Сайнзориг:** Миний асуух гэж байгаа асуулт бол би 2 зүйлээс тодруулж асууя. Шүүх шинжилгээ ба хүний эрхийн талаар маш чухал сэдэв.

Шүүх шинжилгээний байгууллага зөв ажиллаж буюу эргэлзээгүй эргээд энд хүний эрхийн асуудал зөв хангагдаж чадах юм бол гэмт хэрэг зөрчил ч гэсэн хурдан шийдэгддэг. Эргэлзээ байдаггүй. Нөгөө хохирогчийн гэдэг юм уу аль нэг талуудын гомдох сэтгэлгээ багасдаг ийм зүйл байгаа.

Дээрээс нь энд тоног төхөөрөмжөөсөө болоод энэ цогцостой хүндэтгэлтэй хандах энэ тэр бол байхаа больчихсон юм байна лээ. Бүр эмзэглүүлчихээр юм байна лээ шүү дээ. Нярайн цогцсыг хөргөгчдөө хийгээд хадгалж байгаад тэгээд дараа нь төрөл төрөгсөд нь хүлээлгэж өгсөн ч гэх шиг. Аймаар л юм байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чиглэлдээ бид нарт бас тодорхой бодлогын ер нь юу хийх ёстой байна. Энийг нэг хариулж өгөөч.

Дээрээс нь олон нийтийн мэдэх эрхийн асуудал тэр байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль гэлтгүй ер нь Нууцын хуулиуд гээд өргөн баригдаад явж байгаа. Энэ дээр ер нь зүгээр цаашдаа Улсын Их Хурал.

**Х.Баасанжаргал:** 5 дугаар микрофоныг нэе. Энхболд гишүүн.

**Б.Энхболд:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр шүүх шинжилгээ ба хүний эрхийн асуудал сэдвээр илтгэлд дурдсан нэг асуудал бол энэ хүний биед хийх үзлэг шинжилгээний асуудал байгаа. Энэний нэг асуудал нь энэ орон нутагт ажиллаж байгаа энэ алба хаагчдын хөдөлмөрлөх эрх. Дээр нь энэ шинжилгээнүүд бол тодорхой цогцсон дээр хийгддэг мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байх хугацаанд энийг зориулалтын байр хөргүүрт хийх ёстой байдаг. Гэтэл орон нутгийн түвшинд бол энэ нөхцөл байдал бол маш хангалтгүй бөгөөд ерөнхийдөө хэрэглэж байгаа техник тоног төхөөрөмжүүд нь ахуйн хэрэгцээний ийм техник тоног төхөөрөмжүүдийг хэрэглэдэг. хөргөгч, хөлдөөгчийг алба хаагч нар өрөөндөө тавьчихсан. Үүндээ тэр нотлох баримтыг нотлох баримтын дээжүүдийг нь хадгалах, хамгаалах ийм нөхцөл байдалтай байгаад байгаа учраас бодлогын хувьд цаашид энэ шүүх шинжилгээний албыг бэхжүүлэх ялангуяа орон нутагт байгаа энэ бүсийн төвүүд, хэлтсүүдийн техник технологи, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаж байж нотлох баримт бодит хэмжээнд үнэлэгдэх хүний нэр төр эрхэм чанарыг хангах ийм алхам руу ойртох юм байна гэж үзэж энэ чиглэлээр 2 төрлийн саналыг оруулсан байгаа гэж танилцуулъя.

**Х.Баасанжаргал:** 6 дугаар микрофоныг нэе. Нарантуяа гишүүн.

**Г.Нарантуяа:** Сайнзориг гишүүний асуултад баярлалаа.

Үнэхээрийн мэдэх эрх хангагдаж байж Монголд ардчилал оршино. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болоод бусад үнэний тухай ярих орон зай үүснэ. Тийм учраас өнгөрсөн жил ХЭҮК-оос хувийн нууцын асуудлыг дүн шинжилгээ хийж илтгэж байсан. Энэ жил бол мэдэх эрхийн асуудалд иргэний улс төрийн эрхийн хүрээнд илтгэж байгаа юм. Үндсэндээ Монгол Улс, Монгол Улсын иргэний мэдэх эрхийг хангаж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг ХЭҮК хийсэн. Мэдэх эрхийн олон нийтийн мэдэх эрхийг хангах хүрээнд хууль тогтоомж, технологийн олон шинэчлэл санаачилга байгаа боловчиг хэлбэрийн төдий өөрчлөлт байна. Агуулгын өөрчлөлт алга гэдэг дүгнэлтийг хийсэн. Мэдэх эрхийг хангахын тулд 1 дүгээрт нь мэдээллийн орон зайд үйлчилж байгаа олон төрлийн ойлголтуудыг цэгцлэх ёстой, төрийн нууц албаны нууц, байгууллагын нууц, хувийн нууц, тэгээд хязгаартай мэдээлэл, хаалттай мэдээлэл, нээлттэй мэдээлэл гээд мэдээлэл өгөгдлийг зохицуулж байгаа энэ олон нэр томьёо.

**Х.Баасанжаргал:** 6 дугаар микрофоныг нэмэлт нэг минут өгье. Микрофон ассан байна. 6 дугаар микрофон.

**Г.Нарантуяа:** Ойлгомжгүй байгаа нь бол ерөөсөө нууцалмаар байгаа мэдээллээ нууцалдаг. Тэгээд ил болгож байгаа мэдээлэл бол чанарын түвшинд мэдэх эрхийг хангаж чадахгүй байгаа тохиолдол нь олон байгаа. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд тусгайлан тусгах маш тодорхой саналуудыг мөн саналдаа ХЭҮК тусгаж оруулж ирсэн. Баярлалаа.

**Х.Баасанжаргал:** Сайнзориг гишүүн тодруулъя.

**П.Сайнзориг:** Тодруулга дээрээ нөгөө бусад 2 эрхийн сэдвийн хүрээнд нэг тодорхой асуучихъя. Өнөөдөр ингээд Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль гээд маш олон хуулиуд ингээд явж байна уялдааг нь хангахгүй бол сүүлдээ нөгөө хүүхдийн эрхийг хамгаалах биш тогтолцооны хувьд бие биетэйгээ зэрэгцсэн байгаа нөөцөө зэрэгцүүлж үрсэн ийм юм руу явчих вий гэдэг надад болгоомжлол байгаа.

Тэгэхээр ер нь тогтолцооны хувьд бас хүүхдийн эрхийг хамгаалах асуудал дээр юу анхаармаар санагдаж байна? Энэ дээр манай комиссарууд юу гэж бодож байна 1 дүгээрт хэлээч? Ер нь тэгээд энэ Гэр бүлийн тухай хууль явж байгаа. Гэр бүлийн тухай хуулийн үзэл баримтлал энэ тэртэй комиссоос санал авсан уу? Та бид юу гэж бодож байна? Наад захын нэг хүүхдийн эрхийн нэг жижиг зөрчил гаргахад л бараг ээж аав байх эрхийг нь хасна гэгчихсэн байна лээ. Зарим талдаа бид хэд зөв боловч энэний дэнсийг олохгүй бол бас их асуудлууд үүснэ. Энэ дээр ер нь Гэр бүлийн хуулийг та хэд үзсэн үү үгүй юу? Эрүүл мэндээ хамгаалах эрх байна. Маш өргөн ойлголт. Гэтэл өнөөдөр өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалахгүй архи ууж явж байгаад эмнэлгүүдээр очиж.

**Х.Баасанжаргал:** Эрүүл мэндийн эрхтэй холбоотой тодруулгад хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон. Хүүхдийн эрхтэй холбоотой асуултад 4 дүгээр микрофон, Хунан гишүүн, дараа нь эрүүл мэндийн эрхтэй холбоотой асуултад 3 дугаар микрофон.

**Ж.Хунан:** Энэ хүүхэд хамгааллын тогтолцоотой холбоотой зарим асуудлыг бид хөндсөн байгаа. Тэгээд энэ хүрээнд бол хүүхэд хамгааллын тогтолцоог

бүрдүүлдэг 10 бүтэц нэгжийн үйл ажиллагаанд бол үнэлгээ дүн шинжилгээ хийсэн. Үүнээс 4 нэгжийн үйл ажиллагаа бол өмнөх илтгэлүүд дээрээ бол бас дүн шинжилгээ хийж, холбогдох санал зөвлөмжийг хүргүүлж байсан. Энэ хүрээнд бол өнөөдрийн энэ 25 дахь илтгэлийн хүрээнд эдгээр 4 нэгжийн үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан асуудлыг бол нэгд үзсэн байгаа. Тэгээд нэмэлтээр энэ хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор бий болгосон шинэ нэгжүүдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ үнэлгээ бол хийж саналыг бол танилцуулж байгаа.

Тэгэхээр тогтолцооны хувьд бол нэгт гэвэл түрүүн таны хэлсэн энэ хоорондын уялдаа холбоо энэ нийцлийн асуудал бол үнэхээр.

**Х.Баасанжаргал:** 4 дүгээр микрофон нэмэлт нэг минут.

**Ж.Хунан:** Энэ хүрээндээ бол бид нар анхаарах ёстой. Хуулиуд шинэчлэгдэж байгаа. Энэ хүрээнд бол давхардсан ийм чиг үүрэгтэй байж болзошгүй бүтэц нэгжүүд гарах ийм хүлээлт байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол ялангуяа энэ гэр бүлийн маргаанд гэрлэлт цуцлахтай холбоотойгоор хүүхдийн асрамжийг тогтооход шинжээчээр ажилладаг энэ бүтэц маань бол энэ Гэр бүлийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн хүрээнд бол Шүүхийн дэргэдэх энэ гэр бүлийн судлаач гэдэг ийм байдлаар томъёологдож орж байгаа. Ийм өөрчлөлт бол байна. Тэгэхээр шинэ хуулиудыг баталж шинэчлэн найруулахдаа яг одоо байгаа энэ тогтолцооны чиг үүргийг давхар бодолцож энэ дээр давхардахгүй байх, одоо байгаа тогтолцоогоо илүү бэхжүүлэх чиглэлээр ажлуудыг тусгаж оруулах ийм шаардлагатай гэдэг ийм саналыг бол комиссын зүгээс бол.

**Х.Баасанжаргал:** 3 дугаар микрофон Сүнжид дарга.

**Д.Сүнжид:** Сайнзориг гишүүний 2 дахь асуултад хариулъя.

Тэгээд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тийм тохиолдлууд ярьж байна лээ, 2, 3 удаа бид нар хэлэлцүүлэг зохион байгуулсан юм. Тэрэн дээр чихрийн шижин өвчтэй тэрийгээ мэдэж байгаа атлаа өөрөө хүндрүүлчхээд тэгээд дараа нь хүндэрсэн үедээ хяналтдаа ирэхгүй явж байгаад ирдэг гэхчлэн хувь хүний өөрийнх нь эрүүл мэндийн боловсрол ийм юутай холбоотой асуудлууд гарч ирж байгаа. Тэгээд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг энэнтэй холбоотой энэ илтгэл дээр юу гэж дүгнэсэн гэхээр нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг бид нар ингэж нөгөө чухалд үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл нөгөө эрүүл байх тухай ойлголт. Эрүүл мэндээ хянах тухай зөв хэвшил дадал гэдэг энэ ойлголт дээр санхүүжилт ч бид нар төлөвлөхгүй байна. Хамгийн түргэн хасахаараа эрүүл мэндийн салбараас нийгмийн эрүүл мэндээсээ хасчихдаг юм байна лээ. Тэгээд энэ дээр анхаарал өгөхгүй байна. Тиймээс энэнд анхаарал өгөх хэрэгтэй байна гэдгийг нэг сэдэв, дэд сэдэв болгож оруулсан.

**Х.Баасанжаргал:** Цэнгүүн гишүүний микрофийг нэе. Цэнгүүн гишүүн.

**С.Цэнгүүн:** Танилцуулга бэлтгэж хүргэсэн ХЭҮК-ынхондоо баярлалаа. Маш чухал асуудлуудын талаар ойлгомжтой мэдээллийг боловсруулсан байна. Тэгээд өнөөдөр Хууль зүйн байнгын хороон дээр бас давхар орж ирж байгаа Баасанжаргал гишүүнээс өргөн барьсан хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийнхээ талаар Их Хурал дээр Хүний эрх дэд хороон дээр санал, дүгнэлт боловсруулсан ажил хэрэгч хандаад үндсэндээ бол энэ хүүхэд хамгааллын чиглэл

дээр ахицтай зүйлүүдийг оруулж ирж байгаа юм байна. Тэгээд энд үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчны дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүний үр нөлөөг арилгах гээд хариуцлагын тогтолцоог нь оруулж ирж байгаа юм байна.

Тэгээд хүүхдийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодист автахаас урьдчилан сэргийлэх асуудлуудыг ч мөн оруулж ирж байгаа гэдэг нь өөрөө тулгамдсан маш чухал асуудлууд байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг оруулж ирж байгаа нь л их зүйтэй байна гэж үзэж байна. Тэгээд танилцуулгын явцад нэг тоог хараад их гайхлаа. Энэ бодит тоо юм уу үгүй юм уу гэдгийг асуумаар санагдсан. Тэр нь болохоор эрүүл мэндийн тогтолцоо бүрэлдэхүүн хэсгүүд дээр байгаа. Энэ яаралтай тусламжийн хүртээмж дээр 2024 онд 18113 нас баралт бүртгэгдсэнээс аврах боломжтой нас баралт нь 9761 гэж тавьсан байна. Тэгээд энэ чинь бараг 53 хувь нь аврах боломжтой байсан гэдгээр энэ тайлан дээр бүртгэгдсэн байна л даа. Энэ тоо өөрөө маш ноцтой зүйлийг илтгэж байна.

Тэгэхээр энэчээнээс Хүний эрхийн Комиссынхоос дэлгэрүүлж энэ тооны талаар асуумаар байна.

**Х.Баасанжаргал:** 3 дугаар микрофон Сүнжид даргын микрофоныг нэе.

**Д.Сүнжид:** Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ статистик мэдээллийг бид нар ер нь эрх бүхий байгууллагуудаас нь яг хамгийн сүүлийн байдлаар буюу 3 сард бүгдийг нь албан бичгээр авсан тоонууд. Тэгэхээр энэ тоо бол үнэн ийм тоо ирж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол яг таны ойлголт зөв.

Хоёр хүн тутмын нэгийг нь аврах боломжтой гэдэг ийм ангилалд байгаа юм байна лээ. Тийм ирүүлсэн мэдээг танд танилцуулъя. Холбогдох мэдээллийг нь энэнтэй холбоотой танд танилцуулъя.

**Х.Баасанжаргал:** Тодруулах уу Цэнгүүн гишүүн, болчихсон уу?

Би нэг 2, 3 зүйл тодруулаад асуугаадахъя.

Юуны өмнө комиссын гишүүддээ баярлалаа.

Энэ жилийн 25 дугаар илтгэлийн танилцуулга мэдээлэл бол ач холбогдлын бөгөөд бас мэдээллийн эрэмбэ дарааны хувьд ч гэсэндээ маш чухал ийм мэдээллүүд танилцууллаа.

Шүүхийн шинжилгээтэй холбоотой нэг асуулт, хүүхдийн эрхтэй холбоотой нэг асуулт мөн өмнөх илтгэлтэй холбоотой хэрэгжилттэй холбоотой гээд ингээд нийтдээ нэг 3 асуулт асууя.

Нэгдүгээрт энэ шүүхийн шинжилгээний байгууллагын нөхцөл байдал ялангуяа хүүхэд шүүхийн шинжилгээ орж байгаа тохиолдолд хүүхдийн биед үзлэг хийж байгаа тохиолдолд, тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд дээр үзлэг хийж байгаа тохиолдолд тусгай нөхцөл шаардлага тавигдах учиртай. Тэгэхээр энэ шаардлага ер нь хэр биелэлттэй байгаа вэ? Улаанбаатар хот болоод орон нутгийг аль алийг нь ялгаатай байгаа юу гэдэг дээр онцолж хэлээрэй гэж хүсэх гэсэн

юм. Мөн шүүхийн шинжилгээтэй холбоотой ер нь шүүхийн шинжилгээний дүгнэлт чинь өөрөө тэр чигээр тэгээд шүүхийн шийдвэрийн гол нотолгооны хэрэгсэл болдог. Тэгэхээр яг нотлох баримтын шаардлага буюу нотолгооны шаардлагыг энэ шүүхийн шинжилгээний дүгнэлтүүд хэр хангаж чадаж байгаа вэ? Би бол яг нөгөө хуульч хүнийхээ хувьд зарим тохиолдолд үнэхээр санаа зовдог. Шүүх бол шүүхийн шинжилгээний дүгнэлтийг үндсэндээ бүхэлд нь нотлох хэрэгсэл, нотолгооны ач холбогдолтой гээд ингээд шууд үнэлээд шүүхийн шийдвэрийг гаргах хамгийн гол үндэслэл болоод байдаг. Гэтэл яг энэ нотлох баримт маань нь өөрөө цаанаа яг ямар нөхцөлд яг энэ нотлох баримтын шаардлагыг хангахуйц ийм нөхцөл байдал бүрэн бүрдсэн үү үгүй юу гэдэг дээр энэ 2 асуултад хариулаач гэж хүсье.

Хүүхдийн эрхтэй холбоотой асуудал дээр энэ орон нутгийн хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагаа ер нь ямар байна вэ? Үүний хэрэгжилт ямар байна вэ? Энэ зөвлөл үйл ажиллагаагаа төлөвлөхдөө, тайлагнахдаа хянахдаа энэ процесс өөрөө яаж явж байна вэ? Үүнд хүүхдийн оролцоо хэр байна вэ гэсэн ийм асуулт асууя.

3 дугаарт Сүнжид дарга бараг хариулах байх даа. Та хэд маань энэ 25 дугаар илтгэл дээр өмнөх 24, 23 дугаар илтгэл дээр туссан асуудлуудыг дахиж хөндсөн асуудлууд нэлээд байх шиг байна. Ялангуяа хүүхдийн эрхтэй холбоотой асуудлууд байна гээд. Ингээд хэд хэдэн хүний эрх хамгаалагчийн асуудал гээд ингээд өмнөх оны илтгэлүүд дээр туссан боловч, Их Хурлын тогтоол дээр туссан боловч биелэгдээгүй дахиад энэ жил орж ирж байгаа хэчнээн асуудал байна вэ? Нийт илтгэлд туссан санал зөвлөмжийн хэдэн хувийг дахиад өмнөх оны илтгэл, санал, зөвлөмжүүд дахиж нэмж давтагдаад байна вэ яагаад шийдвэрлэгдэхгүй байна вэ гэдэг ийм 3 асуулт асууя.

5 дугаар микрофоныг Энхболд гишүүний микрофоныг нээе.

**Б.Энхболд:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ шүүх шинжилгээний өнөөгийн орчин нөхцөл ямар байна вэ гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр би нэг статистик үзүүлэлтийг хэлэхээр энэ асуултын гол хариулт бий болох байх гэж бодож байгаа юм. Тэгэхээр ер нь 2025 онд орчин нөхцөлийн шаардлага хангаагүй ийм байранд 4024 хүний биед үзлэг хийсэн байгаа юм. Энэ 4024 бол бүгдээрээ нотлох баримт болж шүүх дээр очиж байгаа. Тэгэхээр энэ асуудал маань юутай холбоотой байна вэ гэхээр энэ орон нутагт энэ шүүх шинжилгээний байгууллагуудыг дандаа актлагдчихсан байранд үйл ажиллагаа явуулахыг нь зогсоосон ийм барилга байшингуудад тийм эмнэлгийн орчныг зориудаар өөрийнхөө гарын доорх материалаар гэдэг юм уу ингэж бүрдүүлээд хүний биед үзлэг хийж байгаа асуудал байгаа юм. Энэ дээр бол өнгөрсөн 2025 онд бэлгийн холбогдолтой үзлэгт 160 хүнийг бол ийм зориулалтын бус орчин орон дээр энэ үзлэгийг хийсний 79 нь хүүхэд байгаа юм.

Тэгэхээр энэ үзлэгүүдийг бол эрх бүхий албан тушаалтнууд тайлбарлахдаа бид нар эрүүл мэндийн байгууллага дээр эмнэлэг дээр дагуулж очиж ингэж үзлэг шинжилгээнд хамруулдаг гэж байгаа боловч чанарын ярилцлагаар бол эдгээрийг бол яг тэр зориулалтын бус тэр хонгилын тэр гэрэлгүй хүйтэн, тэр хүний нууцлал, аюулгүй байдлыг хангахгүй орчин нөхцөлд хийгээд явуулаад байгаа юм. Тэгэхээр энийг бол орон нутгийн хэмжээнд анхаарахгүй бол хохирогч дахин хохирох энэ шүүх

хууль хяналтын байгууллагад итгэх итгэл нь бол үнэхээр суларч байгаа нь энэ байгууллагын манай явуулсан хяналт шалгалтаар харагдаж байгаа.

Тэгэхээр энийг нэн даруй шийдэх ёстой гэдэг, таслан зогсоох ёстой гэдэг энэ шаардлагыг бол холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээс гадна бодлогын хувьд энэ зориулалтын орчин нөхцөлийг бий болгох төсөв хөрөнгө бодлогын асуудлыг шийдэх ёстой юм байна гэж ингэж үзэж байгаа.

21 аймагт бол зориулалтын л стандарт шаардсан хангасан лаборатори байхгүй. Энэ лабораторид хийгдэж байгаа бүх шинжилгээ, үндсэндээ нотлох баримтын шаардлагыг хангахгүй байгаа. Энэ нотлох баримтын шаардлагыг хангахгүй байгаа баримтаар хүний гэм бурууг өнөөдөр дэнсэлж байгаа ийм л асуудал явагдаж байгааг бол зайлшгүй анхаарах ёстой. Энэ дээр бол бас бодлогын хувьд анхаарал хандуулж бусад хууль хяналтын байгууллагуудын түвшинд аваачихгүй бол энийг бол завсрын ингээд орхисон нөхцөл байдал байна гэдгийг танд танилцуулъя.

**Х.Баасанжаргал:** 4 дүгээр микрофон Хунан гишүүн.

**Ж.Хунан:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид нар Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл болон Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд бол дүн шинжилгээ хийж ажилласан. Энэ хүрээнд 21 аймгаас бид нар албан бичгээр Орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, мэдээллийг 4 жилийн байдлаар, 5 жилийн байдлаар ирүүлэхийг хүссэн боловчиг баримт бичиг бол хангалттай хэмжээнд бол ирээгүй. Өөрөөр хэлбэл энэ хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл бас хангалттай хэмжээнд ажиллаагүй гэдгийг бол илтгэж байгаа юм. Тэгээд 2025 оны байдлаар жишээ нь Орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс шийдвэр гаргасан 3 аймаг л байгаа юм.

Өөрөөр хэлбэл хуралдаж шийдвэр гаргасан ийм асуудал байна. Төсөв баталсан аймаг жишээ нь.

**Х.Баасанжаргал:** 4 дүгээр микрофоныг нэмж өгье.

**Ж.Хунан:** Хоёрхон аймаг бол төсөв баталсан байгаа. Өөрөөр хэлбэл хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн төлөвлөгөөнд зарцуулж төсөв батлах энэ асуудал бол хангалтгүй хэмжээнд байгаа. Хуралдааны тэмдэглэл хөтөлдөг бас орон нутгийн зөвлөл их цөөхөн. 2025 оны байдлаар харах юм бол 8 хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл бол хуралдааны тэмдэглэл хөтөлсөн ийм байдалтай байгаа. Тэгээд бүрэлдэхүүний хувьд бол харилцан адилгүй ер нь бол энэ хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа бол ийм доголдолтой, ийм тогтмол биш, тогтвортой биш 3 жилд нэг удаа хуралдсан энэ хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөл байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тэгээд энэ дээр бол чухал үүрэг гүйцэтгэдэг ялангуяа энэ чиглэлд зөвлөмж өгөх, хөрөнгө босгох, хөрөнгийг шийдвэрлэх ийм чиг үүрэгтэй Орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаа бол хангалтгүй.

**Х.Баасанжаргал:** Төсөв баталсан 2 аймгийг нэрлээч. 4 дүгээр микрофон.

**Ж.Хунан:** Төсөв баталсан 3 аймаг.

Дорнод аймаг баталсан байна. Өмнөговь аймаг баталсан байна. Энэ 2 аймаг л баталсан байна.

**Х.Баасанжаргал:** Бусад нь төсөв батлаагүй гэсэн үг үү?

**Ж.Хунан:** Бусад нь 2025 онд төсөв батлаагүй гэсэн үг.

**Х.Баасанжаргал:** 3 дугаар микрофон Сүнжид дарга.

**Д.Сүнжид:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Бид нар сүүлийн 5 жилээр зөвхөн тэгэхдээ энэ ХЭҮК-ын өөрийнх нь үнэлгээ байгаа. Монгол Улс дахь хүний эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан Их Хурлын баталсан тогтоолын хэрэгжилтийн үнэлгээ харахаар 2021 оных 71, 2022 оных 62.3, 2023 оных 49, 2024 оных 51, 2025 оных 47 гэдэг хувьтай. Өөрөөр хэлэх юм бол маш хангалтгүй үзүүлэлт байдаг. Энэ дунд давтан давтан явдаг асуудлууд байна. Жишээ нь хүүхдийн эрхийн асуудал. Өнгөрсөн жилийн 2025 оны 77 дугаар тогтоолын хэрэгжилт дээр 6 асуудлыг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалалт дээр авч хэрэгжүүлээч ээ гэсэн хэрэгжилт нь 33 хувьтай гэж гарч байгаа.

Энэ дээр жишээ нь энэ нөгөө хамтарсан баг хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын оролцоог хангах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны оролцоог хангах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой ийм процессын журам мөрдүүлэх гэхчлэн ийм асуудлууд орсон. Хэрэгжилтийг бол манай ХЭҮК 33 хувьтай байна гэж үнэлж байгаа. Энэний өмнөх 2024 оны 37 дугаар тогтоол дээр.

**Х.Баасанжаргал:** 3 дугаар микрофоныг нэмж өгье.

**Д.Сүнжид:** Хамгийн муу хэрэгжилттэй эрх нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх юм. Энэ дээр ялгаагүй хүүхэд яригдна. Бид нар нөгөө дотоод орчны агаарын чанар яригдаж байгаа. Эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллага хүн олноороо зорчдог энэ төвүүдэд дотоод орчны агаарын чанар агаар сэлгэлтийг бий болгох стандартыг батлах тэгээд энэ засвар үйлчилгээг энэ 2 бодис, хортой бодис агуулсан бодисоор хийхгүй байх гээд л явсан. Тэгээд энэний хэрэгжилт жишээлэх юм бол 25 хувьтай, 50-аас доош хувьтай байна.

Хүүхдийн эрхийн талаарх асуудал бол энэ 2024 оны 37 дугаар тогтоолд 50 хувь гээд ийм байгаа юм. Тийм болохоор Сайнзориг гишүүний түрүүн гаргасан саналыг дэмжиж байна. Энэ тогтоолтой холбоотой энэ үүрэг хүлээж байгаа эрх, эрх хэмжээний дагуу чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх ёстой Засгийн газрын байгууллагууд бас энэ тогтоолын хэрэгжилттэй холбоотой тайлбар өгөх, хамт байлцах нь энэ асуудлыг нэгдмэл ойлгоход тустай гэдэг тэр саналыг дэмжиж байгаагаа энэ ташрамд хэлье.

**Х.Баасанжаргал:** Баярлалаа. Илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Илтгэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүнээр тасалбар болгоё. Сайнзориг гишүүний микрофоныг.

**П.Сайнзориг:** Би өөрөө энэ дээр яах вэ зүгээр ач холбогдол өгөөд байгаа шалтгаан маань манай ХЭҮК ийм хэмжээний тайлан мэдээллийг жилийн хугацаанд бэлдээд дүгнээд ороод ирэхэд бид хэд ийм хангалтгүй байдлаар сонсож байгаад нь л эмзэглээд байгаа юм. Би бас намрын чуулганд уг асуудлаар Улсын Их Хурлын дэгийн тухай хууль болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гэж бодож байна. ХЭҮК-ын бэлтгэж ирж байгаа тайлангийн хүрээнд сэдэвтэй хамааралтай албан тушаалтнууд ялангуяа Засгийн газрын гишүүд хуралд суумаар байна. Асууж тодруулмаар байна. Энэ ХЭҮК-ын тайлантай санал нэгдэж байгаа юм уу гэдгийн би байр суурийг нь асууж тодруулмаар байна. Энэ энэ хүний эрхийн зөрчлүүд дээр ямар бодлогын өөрчлөлтүүд хийхээр ажиллаж байгаа юм бэ гэдгийг нь асуудаг болмоор байна.

Тэгэхээр энэ дээр Засгийн газрын гишүүд байж байх ёстой яг холбогдох.

Хоёрдугаарт энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг бид чинь нэг сонсоод байгаа шүү дээ гишүүдээ. Бүх Байнгын хороо сонсож байгаа. Тэр хэрэгжилтийн үр дагаврыг сонсож байгаа асуудлыг энэ ХЭҮК-ын тайлантай уялдуулж тэр сэдвийн хүрээнд нь байгаа хуулиудыг жил болгон бүтнээр нь сонсдог байдал руу ормоор байна. Тэр хууль нь яаж хэрэгжсэн юм? Ямар төсөв зарцуулав? Нийгэмд ямар эерэг нөлөө авчрав, сөрөг нөлөө юу авчирсан юм. Цаашдаа яаж тэр хуулийг нь сайжруулах ажлууд хийх ёстой юм гэдэг зүйлүүдийг илүү их тодорхой болгож өгье өө гэж үзэж байна.

Хоёрдугаарт ийм том хэмжээний буюу энэ өөрөө Улсын Их Хуралд нөгөө батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих энэ ажлыг чинь комисс хүний эрх талаас нь хийж өгөөд байгаа байхгүй юу. Бид нарын ажлыг хийж өгч байгаа юм. Энэ ажлыг хэлэлцэхдээ бид нар энэ цагт баригддаг юмыг нь жоохон өөр дэгтэй болгомоор байна. Тодорхой хэмжээний арай жоохон уужуу, ядаж одоо нэг завсар бүүр хязгааргүй гэж байгаа юм биш. Энэ чинь ерөөсөө гуравхан минутад юу ч амжихгүй байгаа байхгүй юу? 3, 4 минутад.

Тэгэхээр ийм зүйлүүдийг бас нэг тайлан хэлэлцэхэд анхааръя. Тэгээд энэ хуралдаан даргалагч бас Байнгын хорооны санал, дүгнэлтэд оруулж энэ гишүүдэд бас онцгой анхаарал хандуулж өгөөч. Ялангуяа тэр шүүх шинжилгээний байгууллагыг өнгөрсөн парламент бол хууль тогтоомжийг нь сайжруулж өгсөн. Энийг дагаад нөгөө хөрөнгө оруулалт хийхгүй бол ажиллахгүй. Ер нь орчин үед бас цогцост ингээд задланг компьютерын юугаар хийчхээд байгаа шүү дээ. Одоо янз бүрийн байдлаар тэр нөгөө бие эрхтнийг нь онгойлгож янз бүрийн жоохон харахад ч гэсэн хэцүү л байдаг л даа. Тийм зүйлээс чинь татгалзаад энэ дээрээсээ нэмж яана гэвэл ингээд явдаг. Тэгээд ийм юм руу наад захын орчхоод байхад бид нар ерөөсөө хийхгүй байгаа юм. Тэгээд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль дээр би энэ шүүх шинжилгээний байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд буюу гэмт хэргийг таслан зогсоож байгаа хамгийн чухал байгууллага гэж оруулж байж ядаж орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас нэг цогцос засдаг чиргүүлтэй болсон байхгүй юу наад зах нь. Ер нь хэн ч тоохгүй байгаа шүү дээ энийг. Тэгэхээр энийг комисс ингээд гаргаад ирлээ. Энийг нэг бодлогын түвшинд нэг анхааръя.

Тэгээд яг үнэндээ хэлэхэд хувцас формын хувьд ч гэсэн цагдаагийн хувцас форм өмсөөд байгааг болиулах хэрэгтэй. Энэ цэвэр мэргэжлийн хүмүүс ажиллах ёстой ур чадвартаа таарсан цалин хөлс авах ёстой. Тэгээд бид хэд нөгөө боловсон

хүчнийг л тогтоохын тулд цалин хөлсийг нь ингээд цагдаагаас бууруулчихгүйн тулд жишиглээд л явдаг. Тэгээд л дээрээс нь хувцас форм өмсгөөд л явдаг ийм зүйлүүд байдаг юм. Тэгээд хувцас форм өмсөөд буруу жишгүүд гарсан байхгүй юу. 2 хүн зодолдоод бараг биеэ алах дөхсөн чинь мань хувцас формыг нь өмсчихсөн нөхөр зогсоод байсан юм. Тэгээд сүүлдээ асуудал гараад энэ хүн цагдаа форм өмсчихсөн нөхөр чинь энэ гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоодог гэсэн чинь өөрөө тийм чиг үүрэгтэй биш, шүүх шинжилгээний байгууллагын ажилтан байсан байхгүй юу. Дундуур нь орж зогсоод шаардлага тавьж чаддаггүй. Тэгээд наад захын энэ хувцас форм өмсөж байгаа нь хүртэл буруу болчихоод байгаа юм. Тэгээд энд хувцас форм өмсөх гэхээсээ илүүтэйгээрээ дандаа нарийн мэргэ мэргэжлийн хүмүүс ажилладаг эмч нар, сэтгэл зүйч нар, тэгээд тэр санхүүгийн өндөр ур чадвартай хүмүүс байх шаардлагатай. Тэгээд энүүдэд нь таарсан цалин хөлс олгоод энийг шийдэж чадвал энэ нөгөө хэргийн бодит байдлыг тогтоох, хүний эрхийн зөрчил багасах.

**Х.Баасанжаргал:** Баярлалаа. Би өөрөө үг хэлэх юм байна байж байгаарай. Гишүүдийн гаргасан саяын асуулт саналтай холбоотой би нэг нэмээд нэг үг хэлчихье.

Нэгдүгээрт энэ шүүхийн шинжилгээний асуудлыг энэ Хүний эрхийн дэд хороон дээрээ нэг хаалттай байдлаар нэг хэдүүлээ нэг хэлэлцье. Яагаад гэвэл энэ нөгөө нотлох баримтын нэлээн нарийн асуудлууд яригдах учраас зарим хэсгий нь хаалттай, магадгүй зарим хэсгий нь нээлттэй хамгийн гол нь Хууль зүйн яам болоод бусад бодлогын хүмүүсийг нь хамт байлцуулж байгаад тухайлан сонсох ийм ажлыг манай Хүний эрхийн дэд хороо хийе. Тэгээд манай Хүний эрхийн дэд хорооны гишүүд үүнд ач холбогдол өгөөд хүрэлцэн ирээрэй гэж хүсье. Оролцоорой гэж хүсье.

Хоёрдугаарт энэ аймаг орон нутгуудыг би сая зориуд нэрийг нь хэлүүлж байгаа нь хэн яг энэ хүүхдэдээ анхаараад төсвөө батлаад байгаа юм, хэн төсвөө батлахгүй байгаа юм бэ гэдэг чинь л ингээд харагдаж байна гэсэн үг. Үнэн хэрэгтээ бүгдээрээ ингээд хүүхдийн баяраар бүх аймгууд хүүхдийн баяраар 6 сарын 1-нд хүүхдийн баярыг талбай дээрээ тэмдэглэх байх. Гэхдээ ингэж төсөв батлаагүйгээ юу гэж тайлбарлахыг бүгдээрээ харъя. 2 аймаг сая төсөв баталсан байна. Хүүхэд хамгааллаа, хүүхдийн төлөө зөвлөл дээрээ гэсэн үг. Тэгээд бид нар яг үнэн хэрэгтээ ингээд хүүхдийн баяраар зөвхөн баярладгаа. Баяр тэмдэглэсэн хүүхдэдээ анхаарч байгаа мэт ингэж ойлгодог ийм асуудал дээр энэ аймаг орон нутгууд бол дүн шинжилгээ хийх цаг нь болсон байх гэж бодож байна.

Тийм ч учраас Ерөнхий сайдын аймаг орон нутгийн удирдлагуудтай хийх гэрээн дээр хүүхэд хамгааллын асуудлыг заавал нэг гэрээнийх нь нэг шалгуур үзүүлэлт олгож оруулъя гэдэг саналыг Хүний эрхийн дэд хорооноос гаргаж байгаа юм гэдгийг онцолж хэлье.

Тэгээд өнөөдрийн илтгэл хэлэлцүүлэхэд хүрэлцэн ирсэн ХЭҮК-ын дарга гишүүдэд бүгдээрэнд нь баярлалаа. Одоо бид нар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад гишүүд үг хэлж дууссан учраас Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах юм? Би танилцуулах уу? Баасанжаргал танилцуулна.

Пүрэвдорж гишүүн хуралдааны дэгийг сахья.

Өнөөдөр ХЭҮК-ын илтгэлийг ганцхан Хууль зүйн байнгын хорооноос гадна Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос санал, дүгнэлт танилцуулахаар манай Хууль зүйн байнгын хороонд танилцуулахаар ирүүлсэн байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-оос 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.6 дахь хэсэгт заасны дагуу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцлээ.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийн хүүхэд хамгааллын тогтолцооны анхаарах зарим асуудал, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт жендерийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлын талаарх санал зөвлөмжийн танилцуулгыг Байнгын хорооны хуралдаанд ХЭҮК-ын дарга Сүнжид танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа сүүлийн 10 жил цэргийн албанд явсан хэдэн цэрэг, мөн хурдан морины уралдаанд оролцсон хэдэн хүүхэд амь насаа алдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун ХЭҮК-оос хүргүүлсэн шаардлага зөвлөмж хэрэгждэг эсэх, эрчүүдийн эрүүл мэндийн асуудал, амиа хорлолтын дараа хийсэн дүн шинжилгээ байгаа эсэх, осол гэмтэл цочмог, цочмогдуун үеийн сэргээн заслын талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн Засгийн газраас хэрэгжүүлсэн газраас хэрэгжүүлсэн ололттой үйл ажиллагааны талаар тайланд туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Бейсен эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хяналт, эмнэлгийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн зээл төлөлт, ЭМД-ын сангийн санхүүжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан Хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, зөрчлөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд ямар арга хэмжээ авсан. Өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн тулгамдсан асуудал, үр хөндөлт, жирэмслэлтийг бууруулахад цаашид ямар арга хэмжээ авах хариуцлагын тогтолцоог яаж сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг хүн аюулгүй амьдрах, ажиллах орчноор хангагдах ёстой.

Сүүлийн 5 жилийн хугацаанд цахилгаанд цохиулсны улмаас хэдэн хүүхэд ажилд нь нас барсан, энэ талаар хийсэн судалгаа байгаа эсэх, цаашид ямар арга хэмжээ авах талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, орон нутаг дахь эмийн сангууд ЭМД-ын сангаас эм, эмнэлгийн хэрэгслийн хөнгөлөлт авч чадаж байгаа эсэх, хүүхдийн суралцах орчны стандартын хэрэгжилт, сургуулийн анги танхимын агаарын чанарын стандартыг батлах, эрэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

талаар, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах сурч боловсрох эрхийн талаар тайлан туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан Хүн амын ундны усны чанарын үзүүлэлт хангалтгүй байгаагийн улмаас хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа боловсролын байгууллагын анги танхимыг стандартын бус будгаар будсаны улмаас хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар судалгаа хийсэн тайланд туссан эсэх, Сэтгүүлчийн эрх зөрчигдөхөд Хүний эрх Үндэсний Комисс ямар арга хэмжээ авсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара орон нутаг, сум бүрд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллаж байгаа эсэх, чиг үүрэгт туссан ажил үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал ХЭҮК-оос Боловсролын яаманд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх, Боловсролын зээлийн сантай холбоотой асуудлаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Тус илтгэлийн хүрээнд Байнгын хороонд харьяалагдах асуудлын хэрэгжилтийг хангуулах талаар ажиллах хүүхдийн амьд явах эрхийг хангах, нас баралтын шалтгааныг тогтоох, ердийн байх ёстой эрхийг өөрчлөхгүй нь, тоон мэдээллээр жил бүр гаргах, үнэлэх, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун эхний эрсдэлд орсон иргэдийг дараагийн эрсдэлд оруулахгүй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүртээмжийг сайжруулах, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны амьд явах эрхийг хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал ХЭҮК-оос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хуулийн хариуцлага тооцдог байх, хүүхдийн эрхийг хангах талаар тус тус саналаа илэрхийллээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос дараах саналыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж байна. Үүнд:

1.Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, санхүүжилтийг ач холбогдлоор нь эрэмбэлж үзүүлэх үр нөлөөнд үндэслэн тогтоож, зарцуулалтыг нээлттэй, ил тод болгох.

2.Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санг байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах.

3.Хүүхэд хамгааллын салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах.

4.Хүн төвтэй эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхан шатын тусламж үйлчилгээнд алслагдсан бүс нутагт мэдээллийн технологи, холбоо, харилцааны хэрэгслийг ашиглан зайнаас үзүүлэх болон хөдөлгөөнт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг сонгох, хамтран ажиллах гэрээ байгуулахдаа тухайн байгууллагын менежмент, нийгмийн хариуцлага, хүний нөөц, дэд бүтэц, төсөв, хөрөнгө оруулалтын боломжийг харгалзан үзэх байх шалгуур үзүүлэлтийг баталж мөрдүүлэх ил тод байдлыг хангах.

6.Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний улмаас гадаад улсад эмчилгээ хийлгэхтэй холбоотой өрхийн санхүүгийн дарамтыг болон ЭМД-ын сангаас хөнгөлөлт олгох шаардлагатай эмийн нэр төрөл, хүртээмжийг бодит хэрэгцээнд

нийцүүлэн нэмэгдүүлж даатгуулагчаас гарах эмийн зардлыг бууруулах чиглэлээр шийдэл бүхий бодлого боловсруулах.

7. Малчин эрэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилтот арга хэмжээг тусгай үе шаттайгаар хэрэгжүүлэх.

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудын давхардал, хийдлийг арилгаж, нэгдсэн бүртгэл ангиллыг шинэчлэх, техникийн зохицуулалтыг батлах.

9. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхтэй холбоотой аюулгүй ажиллагааны тусгай журам, стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулж мөрдүүлэх.

Байнгын хорооны эрхэм гишүүдээ Улсын Их Хурлын ХЭҮК-ын 25 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье гэсэн ийм санал, дүгнэлт манай Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд иржээ.

ХЗБХ-ны хуралдаанд хүрэлцэн ирсэн ХЭҮК-ын гишүүдэд баярласнаа илэрхийлье. Тэгээд бид бүгдээрээ дараагийн асуудалдаа оръё санал хураалт эхэлнэ.

Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

***Дөрөв. Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх мэдээлэл***

Хэлэлцэх асуудлын 4 дүгээр асуудал дээр нэг санал хураалтыг бид нар хойшлуулсан байгаа. Үүнтэй холбоотой санал хураалтдаа бэлдье.

Хүний эрхийн дэд хорооны саналыг комиссын тогтоолд оруулах тухай. 3 санал хураалт байгаа шүү гишүүдээ. Санал хураалтад бүгдээрээ бэлэн үү.

Санал хураалт явуулъя.

Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Хүний эрхийн дэд хорооноос гаргасан саналыг Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгаж чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар дэмжсэнд тооцлоо.

Дараагийн асуудал.

***“Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү, байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Нарантуяа-Нара гишүүнийг дэмжсэнээр, Уянга Хишиг гишүүнийг дэмжсэнээр авъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 19 гишүүнээс 12 гишүүн дэмжсэнээр санал өгч санал батлагдлаа.

Сая Уянгахишиг гишүүн, Нарантуяа-нара 2 нэмэгдээд 12 гишүүн гэсэн үг. Дараагийн санал хураалт руу оръё.

Дараагийн хэлэлцэх асуудал.

***“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”  
Байнгын хорооны тогтоолын төсөл***

Байнгын хорооны тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Та бүхэн тогтоолын төслийг та бүхэнд тарааж өгсөн байгаа байх.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Байгаа юу? байхгүй байна. Үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой тогтоолын төсөл нэмэгдэж байгаа гэсэн үг. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй учраас санал хураалтдаа бэлдье.

“Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Цогтбаатар гишүүн горимын санал гаргая.

**Д.Цогтбаатар:** Би дэмжиж санал өгсөн. Энэ машин ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөхийг хүсэж байна.

Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлдье.

Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

19 гишүүнээс 11 гишүүн зөвшөөрсөн. Саяын санал хураалт хүчингүй боллоо. Дахин санал хураалт. Дараагийн санал хураалтдаа оръё.

Түүрүн томъёолсноороо дахин санал хураалт явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

19 гишүүнээс 11 гишүүн зөвшөөрч, 57.9 хувиар тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

14.10 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА